

2015

Тогтвортой Бичил Уурхай Төсөл (Үе шат 4): Зорилтот бүлгийн дунд мэдлэгийн төв бий болгох судалгаа



IRIM Судалгааны Хүрээлэн
45-р байр 30 тоот, 8-р хороо
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар 14201,
Монгол Улс
Утас/Факс: 976-70117101, Имэй: contact@irim.mn
<http://www.irim.mn>

АГУУЛГА

1. Хураангуй.....	3
2. Оршил.....	5
3. Арга зүй.....	7
4. Үр дүн ба дүгнэлт	9
4.1. Судалгаанд оролцогчдын хүн ам зүйн мэдээлэл	9
4.2. Мэдээллийн эх үүсвэр, хүртээмж.....	13
4.3. Мэдлэгийн төвийн хүрээ.....	16
4.4. ТБУ төслийн талаар мэдлэг хандлага	21
5. Зөвлөмж.....	24
5.1. МТ-ийн мэдээлэл солилцох аргачлал.....	24
5.1.1. Оршил.....	24
5.1.2. Одоогийн нөхцөл байдал.	24
5.1.3. Зорилт; ТБУ Төсөл.....	24
5.1.4. Мэдээлэл солилцох боломжит аргууд.	25
5.1.5. Зорилт.....	26
5.1.6. Мэдээлэл хүлээн авагчид.	26
5.1.7. Гол мессеж.	26
5.1.8. Хэрэгжилт (үе шаттай).	27
5.1.9. Сурталчилгаа.....	32
5.1.10. Төсөв.....	32
5.1.11. Хуваарь.....	33
5.1.12. Мониторинг, үнэлгээ.....	33
5.2. ТБУ Төсөл (4-р үе шат).....	33

1. ХУРААНГУЙ

2015 оны 5-р сарын 2-17-ны хооронд Тогтвортой бичил уурхай /ТБУ/ төслийн 4-р үе шатны хүрээнд “Зорилтот бүлгийн дунд мэдлэгийн төв бий болгох судалгаа”-г Монгол Улсын нийт 9 аймгийн 15 суманд зохион байгууллаа. Судалгаа нь дараах үндсэн зорилттой. Үүнд:

- Мэдлэгийн төв /МТ/-д хамгийн тохиромжтой, үр дүнтэй мэдээлэл солилцох арга хэрэгслийг тодорхойлох,
- МТ-ийг хэрхэн тогтвортой авч үлдэх,
- ТБУ төслийн талаарх бичил уурхайчдын санал сэтгэгдлийг үнэлэх.

Судалгаанд нийт 454 иргэн оролцсон ба тэднээс дараах аргуудаар мэдээлэл цуглуулсан. Үүнд:

- 8 удаагийн фокус бүлгийн ярилцлага /ФБЯ/ (нийт 71 хүн оролцсон),
- 19 удаагийн ганцаарчилсан буюу гүнзгийрүүлсэн ярилцлага /ГЯ/ (/9 асуулт бүхий),
- 364 асуумж (23 асуулт бүхий).

Асуумж судалгаанд оролцсон бичил уурхайчид хүн ам зүйн олон бүлгийг багтаасан буюу нас, хүйс, бичил уурхайд ажилласан хугацаа зэргээрээ харилцан адилгүй байсан ба дийлэнх нь бичил уурхайгаас олсон орлогоор амьдардаг. Тэд уул уурхайн талаарх мэдээллийг гол төлөв орон нутгийн ТББ, иргэдийн уулзалт хурал, бичил уурхайчид, телевиз болон төслийн үйл ажиллагаанаас дамжуулан хүлээн авдаг. Тэдний зөвхөн дөрөвний нэг нь ухаалаг утас ашигладаг, гэвч тэд утсаа өдөрт дунджаар хоёр цаг гаруй хугацаанд ашигладгийн ихэнхийг Facebook орж өнгөрөөдөг.

Асуумж судалгаанд оролцсон иргэд уул уурхайн талаар ямар мэдээлэл авах сонирхолтой байгааг мөн тодруулсан. Ухаалаг утастай хүмүүсийн ихэнх нь бичил уурхайчдад зориулсан тусгай хуудсыг ашиглах сонирхолтой байгаагаа илэрхийлсэн. Ерөнхийдөө бичил уурхайчид МТ нь ТБУ төслөөс зохион байгуулах уулзалт хэлбэртэй байхыг дэмжсэн ба уулзалт нь сард нэг удаа, ажлын талбар дээр эсвэл сумын төв дээр зохион байгуулбал илүү тохиромжтой гэж үзэж байна.

ГЯ болон ФБЯ-д оролцогчид уулзалт нь уул уурхайн талаар мэдээлэл солилцоход тохиромжтой арга хэрэгсэл болохыг мөн дэмжсэн. Тэд мөн уулзалт хэлбэртэй МТ-ийн сул талуудыг, ялангуяа зардалтай холбоотой асуудлуудыг гаргаж ирсэн. Үүний зэрэгцээ, уулзалтаас гадна телевиз зэрэг мэдээлэл солилцох өөр арга хэрэгслүүдийг тодорхойлж байв. Уулзалт нь хамгийн ихээр дэмжигдэж байгаа ч гар утас ТБУ төслийн МТ-д хамгийн тохиромжтой мэдээлэл солилцох арга хэлбэр байж болох юм. Учир нь гар утсаар текст мессеж явуулах, ухаалаг утастай иргэд утсаараа интернэт ашиглах боломж нээлттэй байна.

ТБУ төслийн харилцаа холбооны арга хэлбэр нь шилжилтийн шинж чанартай буюу төсөл хэрэгжих гурван жилийн хугацаанд төслийн одоо явуулж буй

уулзалтуудыг хэвээр үргэлжлүүлж, үүгээрээ дамжуулан аажимдаа интернэт орох боломжтой ухаалаг утасны хэрэглээг нэмэгдүүлэхэд чиглэх нь зүйтэй болов уу. Солилцох мэдээллийн хүрээ нь одоо уулзалтын тоогоор хязгаарлагдаж байгаа ч яваандаа ухаалаг утасны тусламжтай интернэтийн хэрэглээ нэмэгдэхийн зэрэгцээ мэдээллийн багтаамж, цар хүрээ ч мөн өргөжинө. Уулзалтаас ухаалаг утас руу шилжиж буй энэхүү арга хэлбэр нь зардлын хувьд улам бүр хэмнэлттэй арга хэлбэр рүү шилжинэ. Шилжилт хэр үр дүнтэй явагдах нь уулзалтуудаар гарсан ахиц дэвшил, хүмүүсийн ухаалаг утас хэрэглэх сэдэл болон мэдлэг чадвар нэмэгдэж буй эсэхээс хамаарна.

ТБУ төсөл нь бичил уурхайчдын дунд нэлээд өргөн танигдсан /асуумжид оролцогчдын 71,7%, ФБЯ-д оролцогчдын 9,01%/ ба төслийн талаар жигд сайнаар үнэлж / “дунд зэрэг, сайн, маш сайн” гэж үнэлсэн хэсэг нь тус бүр 83,9% ба 88,4%/ байв. Тэдний дунд танигдсан шалтгаан нь сургалт, дэмжлэг, хамтын ажиллагааны үр дүн гэж үзсэн. Төслийн талаар сөрөг хандлагатай байгаа цөөн хэсэг нь үүний шалтгааныг “мэдээлэл хангалтгүй, тогтвортой биш” зэргээр тайлбарлаж байна. Эдгээрийг дараах байдлаар тайлбарлаж болох юм. Үүнд:

- Оролцогч талууд ТБУ төслөөс маш өндөр хүлээлттэй байдаг,
- Одоогийнхоос ч илүү мэдээлэл авах хэрэгцээтэй /санал болгож буй МТ үүнд хариу өгөхөд чиглэгдэнэ/,
- ТБУ төслийг илүү урт хугацаанд тогтвортой хэрэгжээсэй гэсэн хүлээлттэй /санал болгож буй МТ мөн энэ асуудалд хариу өгөхөд чиглэгдэнэ/ байдаг.

Газар нутгаар аваад үзвэл ТБУ төслийн талаарх мэдлэг хандлага судалгаанд хамрагдсан сумдад харьцангуй ялгаа багатай байгаа нь харагдсан.

2. ОРШИЛ

ТБУ төслийн 4-р үе шатны гол зорилго нь “Эдийн засгийн хувьд тогтвортой, байгаль орчны хариуцлагатай, хүний эрхэд суурилсан Монгол Улсын бичил уурхайн салбар нь бичил уурхайтай холбоотой олон улсын туршлагаас үр шимийг хүртэхийн зэрэгцээ өөрөө хувь нэмэр оруулах”-д чиглэгдэнэ.

Төслийн Бүрэлдэхүүн хэсэг 3 нь мэдлэг хуваалцах ба бичил уурхайн талаар дэлхийн хэмжээний бодлогын хэлэлцүүлэг өрнүүлэх: Монгол Улсын оролцогч талууд бичил уурхайтай холбоотой өөрсдийн бий болгосон болон олон улсын сайн туршлагад хувь нэмэр оруулах, түүнээс суралцах, нэвтрүүлэх; Монгол Улсын хүрсэн амжилтыг үндэсний болон олон улсын хэмжээнд бататгах; Монгол Улс болон ШХА нь бичил уурхайн салбарт олон улсын түвшинд манлайлагч байна гэсэн зорилттойгоор хэрэгжиж байна.

Энэхүү тайланд дурдсаны дагуу судалгаа нь дараах зорилттой. Үүнд:

- Бичил уурхайчид, орон нутгийн удирдлагатай харилцах орон нутгийн онцлогт тохирсон мэдээллийн хамгийн үр дүнтэй, хэмнэлттэй арга замыг олж тодорхойлох,
- МТ-ийн вэб хуудсыг зорилтот бүлэгт илүү үр өгөөжтэй болгох.

Түүнчлэн, судалгаагаар ТБУ төслийн талаарх иргэдийн дундах мэдлэг хандлагыг мөн тодорхойлох зорилт тавьсан.

Гэрээт ажлын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Ажлын даалгавар /тусад нь үзэх боломжтой/ болон ШХА-д танилцуулсан Техникийн саналд тусгасан болно.

Судалгааны тайлангийн эхний хувилбарыг ТБУ төслийн багт 2015 оны 5 дугаар сарын 11-нд илгээж, 5 дугаар сарын 15-нд тайлан санал авсан. Саналын дагуу холбогдох засварыг оруулж /график, хавсралт/, МТ-ийн мэдээлэл харилцааны арга хэлбэрийн талаарх дэлгэрэнгүй зөвлөмжийг /дэд бүлэг 5.2./ мөн оруулсан. Эдгээр засвар өөрчлөлтийг 5 дугаар сарын 19-нд ТБУ төслийн багийнханд хийсэн танилцуулгад мөн багтаасан.

Танилцуулгын үеэр дараах саналууд цугласан. Үүнд:

- Зарим тодорхой уул уурхайн үйл ажиллагааны хувьд “хууль ёсны” гэх нэр томъёоны оронд “албан ёсны” гэдэг үгийг ашиглах,
- Асуумжинд оролцсон иргэдийн хүн ам зүйн үндсэн мэдээллийг харуулах /нас, хүйс, байршил, уул уурхайн туршлага, г.м./
- Санал болгож буй МТ-ийн мэдээлэл харилцааны арга хэлбэр, агуулгыг илүү дэлгэрүүлэх,
- Зарим респондентийн судалгаанд оролцсон эсэхийг шалгах.

Зорилтот бүлэгтээ хүрсэн эсэхийг шалгах тухайд судалгааны оролцогчийг сонгох нарийвчилсан арга барилыг Техникийн саналд тусгасан. Талбарын ажлын үеэр судлаачид дараах оролцогч талуудаас мөн мэдээлэл зөвлөгөө авсан. Үүнд:

- Монголын бичил уурхайчдын нэгдсэн холбооны Гүйцэтгэх захирал,
- Орон нутгийн бичил уурхайчдын ТББ-ууд

Ерөнхийдаа судалгааны ажлын хувьд зарим үед судалгаанд оролцоогүй хүмүүс ойр орчных нь хүмүүс оролцож, харин өөрсдөө уригдаагүйд сэтгэл гонсгор үлдэх тохиолдол гардаг. Энэ судалгааны хувьд судлаач өөр нэгэн албан бус бичил уурхайн ТББ-ын төлөөллийг /Говь-Алтай аймгийн Есөнбулаг сум/ оролцуулахаас татгалзсан тохиолдол гарсан. Магадгүй энэ явдлаас болж гомдол ирсэн байхыг үгүйсгэхгүй ба судлаачийн зүгээс нэгээс илүү бичил уурхайн талбартай таарч, судалгааны зорилтыг хадгалахын тулд албан ёсны талбарыг сонгосон нь энэ юм.

Танилцуулгын үеэр өгсөн бусад бүх саналыг тайлангийн холбогдох хэсгүүдэд нэмж оруулан, 2015 оны 5 дугаар сарын 22-нд ТБУ төсөлд хүргүүлсэн болно.

3. АРГА ЗҮЙ

2015 оны 3 дугаар сарын сүүлээр гэрээ /Хавсарлт 1/ хийгдмэгц, ИРИМ судалгааны хүрээлэн ТБУ төслийн багтай хамтран судалгааны хэрэглэгдэхүүнийг бэлдэж эхэлсэн. Төслөөс өгсөн холбогдох баримт бичгүүдтэй мөн танилцсан /Хавсарлт 2/.

Төслийн мэдээллээс харахад вэбэд суурилсан МТ нь хэдийгээр ТБУ төслийн хувьд хамгийн тохиромжтой байж болох ч вэбэд суурилаагүй өөр арга замуудыг судалж үзэх үүднээс хэрэглэгдэхүүнд бага зэрэг өөрчлөлт орсон. Жишээ нь, “хэзээ”, “хаана” гэсэн асуултуудыг уулзалтад оролцох сонирхолтой хүмүүсээс асуусан. Үүний адил, орон нутгийн интернэтийн хурдын талаарх асуултыг судлаачид өөрсдөө тодорхойлж чадах тул асуумжаас хассан.

Судалгааны бүх хэрэглэгдэхүүн болон ФБЯ, ГЯ, асуумжийн драфтыг 4 дүгээр сарын 9-нд захиалагчид хүргүүлсэн билээ.

Судалгааны хэрэглэгдэхүүнийг турших ажил 4 дүгээр сарын 11-нд Төв аймгийн Борнуур суманд явагдсан. Хавсарлт 3-т оруулсан туршилт судалгааны үр дүнд дурдсаны дагуу хэрэглэгдэхүүнд бага зэрэг өөрчлөлт орсон. Тухайлбал, Facebook хэрэглээний талаарх асуултыг илүү дэлгэрүүлж, Facebook хэрэглэгчийн нэр хаягийг тэмдэглэхээр өөрчилсөн. Эдгээр гурван хэрэглэгдэхүүний эцсийн хувилбарыг Хавсарлт 4, 5, 6-д оруулсны дагуу мөн Ажлын даалгавартай хэрхэн нийцэж буйг харуулах үүднээс дараах хүснэгтэд багцлав.

Хүснэгт 1. Судалгааны хэрэглэгдэхүүний хураангуй агуулга (Асуумж, ФБЯ, ГЯ)¹

#	Сэдэв	Параметр/Асуулт	Баримт бичгийн судалгаа	ФБЯ	ГЯ	Асуумж
1	Оролцогчдын' хүн ам зүйн мэдээлэл	Нас				2 ²
		Хүйс				3
		Байршил				4
		Бичил уурхайн туршлага				1
2	Мэдээллийн эх үүсвэр	Ухаалаг утас хэрэглэгчдийн хувь	+			6/7
		Хамгийн их үздэг телевизийн суваг	+			9
		Интернэт ашиглах арга хэрэгсэл				10/11
		Телевиз үзэх, интернэт ашиглах хугацаа				8
		Уул уурхай болон бичил уурхайн талаар авах хүсэлтэй байгаа мэдээлэл		1.1/1.2		11/13
		Туршлага солилцох арга		1.3	5	12
		Бичил уурхайтай холбоотой мэдээллийн сэдэв		1.3		14
3	Компьютерийн хэрэглээ,	Интернэт ашиглах боломж	+			
		Телевиз үзэх боломж	+			

¹Техникийн саналын Хүснэгт 1-д үндэслэв

²Холбогдох сэдэв (асуумж, ГЯ, ФБЯ)

	мэдээллийн бусад эх үүсвэрийн хэрэглээ	МТ-ийн ач холбогдлын талаарх үзэл хандлага			6	
		МТ-ийг хөгжүүлэх боломж			2/3	
4	МТ-д оруулах хувь нэмэр, зорилтот бүлэг бүрээр	Хариуцах эзэн, мэдээлэл шинэчлэх давтамж		1.3	7	
		Мэдээллийн агуулга		1.3	8	
		Вэб сайтын мэдээллийг шинэчлэх, мэдээлэл нэмэх тохиромжтой арга		1.3	2	
5	Зорилтот бүлэг олон улсын ба үндэсний туршлагыг авч хэрэгжүүлэх	Сайн туршлага гэдгийг зорилтот бүлэг хэрхэн тодорхойлох		1.3	√	
		Сайн туршлагыг хэрэгжүүлэх боломж, чадавхи			9	
6	ТБУ төслийн талаарх мэдлэг хандлага	ТБУ төслийн талаарх мэдлэг хандлага		2.1		17/18
		Зорилтот бүлгийн мэдлэг		2.1		15
		Төслийн үйл ажиллагаан дахь оролцоо		2.1		16
		Туршлага солилцох талаар санал			4	

Туршилт судалгаагаар сумдад компьютерийн хэрэглээ маш бага байгаа нь ажиглагдсан. Жишээ нь Борнуур суманд интернэт ордог зөвхөн ганц компьютер байдаг аж. Энэ нь талбарын судалгаанаас өмнө хийгдсэн баримт бичгийн судалгаагаар илэрч байв.

Талбарт мэдээлэл цуглуулах ажил 4 дүгээр сарын 17-оос 5 дугаар сарын 2 хүртэл Техникийн саналд тусгасантай ойролцоо хөтөлбөрөөр явагдсан.

Хүснэгт 2. Талбарын ажлын байршил

Аймаг	Сум	Хэрэглэгдэхүүн		
		ФБЯ	ГЯ	Асуумж
Баянхонгор	Баян-Овооо	1	-	24
	Бөмбөгөр	1	-	24
	Галуут	-	2	24
	Жаргалант	-	2	24
Дархан-Уул	Шарын гол	-	2	24
Дорноговь	Айраг	1	-	24
Дундговь	Хулд	-	2	24
Говь-Алтай	Есөнбулаг	-	2	24
Хэнтий	Норовлин	1	-	24
Сэлэнгэ	Баруунхараа	1	-	24
	Мандал	1	-	27
	Орхонтуул	-	2	24
	Түнхэл	-	2	24
Төв	Заамар	1	-	25
Увс	Тариалан	1	-	25
Улаанбаатар		-	5	0
Нийт		8	19	365


Талбарын ажил дуусмагц ФБЯ, ГЯ болон асуумжийн үр дүнд дүн шинжилгээ хийх ажил эхэлсэн. ФБЯ-ын хураангуйг Хавсралт 8-д, ГЯ-ын үр дүнг Хавсралт 9-д оруулав.

4. ҮР ДҮН БА ДҮГНЭЛТ

4.1. Судалгаанд оролцогчдын хүн ам зүйн мэдээлэл

Үр дүн. Асуумжид оролцсон иргэдийн дийлэнх нь (61,3%) эрэгтэй байсан бол ФБЯ-д эрэгтэй, эмэгтэй тэгш буюу 50%, 50% оролцсон.

Респондентуудын нас 18-67 хооронд ба дундаж нас нь 39,2 байсан.



Дүрслэл1. Насны хуваарилалт(асуумжид оролцогчид)

Үүнтэй адилаар бичил уурхай дахь туршлага буюу ажилласан жил нь нэгээс 23 жил хүртэл маш ялгаатай ба дунджаар 6,8 жил байв.



Дүрслэл2. Бичил уурхайд ажилласан жил (асуумжид оролцогчид)

Бүх респондентийн гуравны хоёр нь уурхайн үйл ажиллагаанд ямар нэгэн байдлаар идэвхитэй оролцдог. Үүнд:

Энэ жилээс оролцож байгаа	77.5%
Бичил уурхайд тогтмол ажилладаг	80.8%
Бичил уурхайтай холбоотой үйл ажиллагаанд оролцдог	66.8%
Өрхийн орлого нь бичил уурхайгаас хамааралтай	93.1%

Ихэнх өрхийн хувьд бичил уурхай нь өрхийн орлогыг бүрдүүлж байна.

Дүгнэлт. Асуумжид оролцогчид нас, хүйс, уурхайн туршлагын хувьд харилцан адилгүй. Гуравны хоёроос илүү хувь нь саяхан бичил уурхай эрхэлж эхэлсэн бол 93,1% нь бичил уурхайгаас өрхийн орлогынхоо тодорхой хувийг бүрдүүлдэг.

Харьцуулсан тоололтын үр дүнд дараах хамаарлууд гарсан. Үүнд:

- Ухаалаг утасны хэрэглээ хүйсээс үл хамаарч байна
- Интернэтэд хандалт эрэгтэйчүүдийн хувьд түлхүү
- Интернэт ашиглах хугацааны хувьд хүйсээс үл хамаарна
- Албан ёсны зөвшөөрөлтэй бичил уурхайчид илүү удаан ажилласан туршлагатай
- 1-5 жилийн туршлагатай залуу бичил уурхайчид Facebook түлхүү хэрэглэдэг
- ТБУ төслийн талаарх мэдлэг хандлага хүйсээс үл хамаармал
- Албан ёсны уурхайчид ТБУ төслийн талаар илүү эерэг хандлагатай

Хэдийгээр ялгаа нь маш бага ч эдгээр хамаарал статистик ач холбогдолтой болох нь батлагдсан.

Судалгаанд хамрагдсан бичил уурхайчдын статус /албан ба албан бус/ нь тэдний хамаарах ТББ-ын өгсөн хариулт дээр үндэслэсэн болно. Статусын талаар өгсөн мэдээлэл нь зөвхөн судалгаанд хамрагдсан талбарын хувьд яригдах ба тухайн сум тэр чигээрээ албан эсвэл албан бус гэж ойлгох нь өрөөсгөл юм.

Хүснэгт 3. Бичил уурхайчдын үйл ажиллагааны статус

Аймаг	Сум	Статус ³
Баянхонгор	Баян-Овоо	Албан
	Бөмбөгөр	Албан бус
	Галуут	Албан
	Жаргалант	Албан бус
Дархан-Уул	Шарын гол	Албан
Дорноговь	Айраг	Албан бус
Дундговь	Хулд	Албан
Говь-Алтай	Есөнбулаг	Албан бус
Хэнтий	Норовлин	Албан бус

³Орон нутгийн ТББ-ын өгсөн мэдээлэлд үндэслэв.

Сэлэнгэ	Баруунхараа	Албан
	Мандал	Албан
	Орхонтуул	Албан бус
	Түнхэл	Албан
Төв	Заамар	Албан бус
Увс	Тариалан	Албан бус

Респондентуудын шинж чанарын талаарх үндсэн мэдээллийг /нас, хүйс, туршлага/ дараах хүснэгтэд нэгтгэн харуулж байна.

Хүснэгт 4. Респондентуудын нас, хүйс, туршлагын тархалт (%); газарзүйн байршлаар

Аймаг	Сум	Түүвэр	Нас (жил)				Хүйс		Туршлага (жил)			
			≤30	31-40	41-50	≥51	Эрэгтэй	Эмэгтэй	≤5	6-10	11-15	≥16
Баянхонгор	Баян-Овоо	24	38	13	17	33	46	54	42	46	12	0
	Бөмбөгөр	24	17	29	33	21	50	50	33	58	8	0
	Галуут	24	21	33	25	21	54	46	59	13	25	4
	Жаргалант	24	38	13	25	25	79	21	54	46	0	0
Дархан-Уул	Шарын гол	24	13	50	21	17	67	33	29	29	17	25
Дорноговь	Айраг	24	9	38	25	29	63	38	29	42	25	4
Дундговь	Хулд	24	58	13	21	8.5	42	58	100	0	0	0
Говь-Алтай	Есөнбулаг	24	29	38	25	8.5	50	50	83	17	0	0
Хэнтий	Норовлин	24	42	25	21	12	50	50	75	21	4	0
Сэлэнгэ	Баруунхараа	24	42	25	17	16	83	17	50	29	13	9
	Мандал	27	7	41	37	15	74	26	0	22	41	37
	Орхонтуул	23	13	26	35	26	83	18	26	56	14	4
	Түнхэл	24	21	33	42	4	71	29	63	38	0	0
Төв	Заамар	25	4	44	44	8	24	76	36	32	32	0
Увс	Тариалан	25	60	32	8	0	84	16	68	32	0	0
Нийт/ Дундаж		364	27.2	30.2	26.4	16.2	61	39	49	32	13	6


4.2. Мэдээллийн эх үүсвэр, хүртээмж

Үр дүн. Респондентуудын зөвхөн 27,3% нь ухаалаг утас ашигладаг ба эдгээрийн 84,6% нь Android системд суурилсан утас /LG, Motorola, Samsung, Sony, г.м./ ашигладаг ба үлдсэн 15,4% нь бусад төрлийн ухаалаг утас /iOS системд суурилсан iPhone, г.м./ хэрэглэж байна.

Респондентуудын дотор гар утсаар интернэт хэрэглэгчдийн дунд үүрэн телефоны операторууд дараах байрыг эзэлж байна. Үүнд:

Юнитель	38.6%
Мобиком	37.0%
Ж-мобайль	15.6%
Скайтель	8.7%


Судалгаанд оролцогчдын дийлэнх олонхи нь (81,9%) нь радио огт сонсдоггүй, ба радио сонсдог 18,1% нь өдөрт дунджаар 2,2 цагийн турш сонсдог байна. Харин бараг ихэнх оролцогчид /94,2%/ телевиз үздэг ба үүнд өдөрт дунджаар 3,8 цаг зарцуулдаг аж. Интернэтийн хэрэглээ 23,6%-аар хязгаарлагдаж байгаа ба хэрэглэгчид нь өдөрт 2,1 цагийг зарцуулж байна.



Дүрслэл3. Мэдээллийн хэрэгслийн өдрийн дундаж ашиглалт

Телевиз үзэгчдийн хувьд хоёр телевизийн суваг /MYONT, TV9/ хамгийн түгээмэл /тус бүр 32,4%, 18,9%/ байна. Бусад 11⁴ суваг нь нийлээд 33,0% эзэлж байна. “Бусад” гэсэн сонголтыг нийт оролцогчдын 15,7% сонгосон ба үүнд “Малчин” телевиз болон Moviebox хамгийн өндөр хувь эзэлжээ /нийт хариултын 8,2% болон 3,2%/.

⁴ Eagle TV, Боловсрол, Эх орон, орон нутгийн TV, MN25, Mongol HD, NTV, SBN, TB5, TV8, UBS



Дүрслэл 4. Респондентуудын дунд хамгийн түгээмэл 15 телевизийн суваг

TV9 хамгийн түгээмэл байгаа нь тухайлбал, утсаар үзэгчидтэй холбогддог “Монгол коммент” нэвтрүүлэгтэй холбоотой байж болох юм.

Интернэт хэрэглэдэг дөрөвний нэгийн хувьд ихэнх нь /75,6%/ гар утас ашиглан гэрээсээ, интернэт кафе болон ажлын байран дээрээсээ ордог /тус бүр 12,4%; 10,3%; 1,6%/ . Интернэт ашигладаг 23,6%-ийн хувьд Facebook хэрэглээ давамгайлж /58,6%/ байна. Интернэт орох дараачийн талбар нь орон нутгийн захиргааны байр /7,5%/ болон бусад /12,0%/ . Эдгээр респондентын дунд Facebook хэрэглээ нь харьцангуй жигд тархацтай /”тогтмол, хааяа, ховор/ буюу тус бүр 30,3%, 23,3%, 41,9% байна.



Дүрслэл 5. Респондентуудын дундах вэбсайтын хэрэглээ

Бичил уурхайчдын мэдээллийн эх үүсвэрийн хувьд хамгийн чухал тав нь дараах хэрэгслүүд байв. Үүнд:

ТББ-ын үйл ажиллагаа	19.9%
Иргэдийн уулзалт (ТББ, төсөл, г.м.)	19.3%
Бичил уурхайчид	16.1%
Телевиз	14.9%
Төслийн үйл ажиллагаа	11.5%



Дүрслэл 6. Уул уурхайн талаар мэдээлэл авдаг эх үүсвэрүүд

Дүгнэлт. Ухаалаг утасны хэрэглээ судалгаанд оролцогчдын 27,3%-ийг эзэлж байгаа ба эдгээрийн олонхи нь Android төрлийн утас ашиглаж байна. Юнител, Мобиком гэсэн хоёр операторын сүлжээг түлхүү ашиглаж /75,6%/ байна. Ухаалаг утастай иргэдийн ихэнх нь интернэт ордог ба /гол төлөв хөдөлгөөнтэй/ тэр дундаа Facebook ашиглагчдын тоо харьцангуй давамгай /58,6%/ байна.

Радио сонсох нь нэлээд ховор /18,1%/ ба сонсдог хүмүүс нь өдөрт 2,2 цаг зарцуулдаг бол МҮОНТ болон TV9 сувгийг ихээр сонирхож үздэг аж. Оролцогчдын дийлэнх олонхи нь /94,2%/ телевизээс түлхүү мэдээлэл авдаг ба өдөрт арай удаан хугацааг зарцуулж /3,8 цаг/ байна. Интернэт хэрэглэгчид 23,8% ба ухаалаг утастай хүмүүс өдөрт 2,1 цагийг зарцуулдаг.

Телевиз нь мэдээллийн хэрэгслүүдээс хамгийн өндөр хувьтай байгаа ч бичил уурхайчдын уул уурхайн талаар мэдээлэл авдаг гол эх үүсвэрүүдийн 4-т орж, харин ТББ, иргэдийн уулзалт, бичил уурхайчид өөрсдөө гэсэн хариултуудын дараа орлоо.

4.3. Мэдлэгийн төвийн хүрээ

Үр дүн. Хамгийн чухал сэдвийн хүрээнд зургаан төрлийн сэдэв ялгарч байна. Үүнд:

- Бичил уурхайн талаарх ерөнхий мэдээлэл,
- Засгийн газрын бодлого /жишээ нь, бичил уурхайг хэрхэн дэмжих/
- Эрүүл ахуй, аюулгүй ажиллагаа
- Нөхөн сэргээлт
- Лиценз хуваарилалт
- Хууль эрх зүй /жишээ нь, бичил уурхайчдын эрхийг хамгаалах/

Бусад сэдвийг дараах дүрслэлд харууллаа.



Дүрслэл7. Респондентуудын хувьд хамгийн чухал сэдэв

Интернэт хэрэглэгчдийн дунд ихэнх нь /91,6%/ бичил уурхайчдад зориулсан Facebook хуудсыг ашиглах хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн ба өөрсдийн Facebook-ийн хэрэглэгчийн нэрийг өгсөн /Хавсалт 10/.

Төсөл МТ-ийн уулзалтууд зохион байгуулах тохиолдолд уулзалтын хамгийн тохиромжтой байршлыг дараах байдлаар сонгосон. Үүнд:

Ажлын талбар дээр	52.5%
Сумын төвд	36.3%
Аймгийн төвд	8.2%
Бусад ⁵	2.9%

Хамгийн тохиромжтой давтамж нь сард нэг удаа гэж үзэж байна.

Улиралд нэг удаа	27.1%
Сард нэг удаа	51.9%

⁵ 'Would not participate', 'anywhere', 'Ulaanbaatar' and 'do not know'.

2 долоо хоногт нэг	9.0%
Долоо хоног тутам	5.1%
Бусад ⁶	7.0%

Хэдийгээр харьцангуй олонхийн хувьд (58,3%) иймэрхүү уулзалтын хугацаа нь тийм ч чухал биш ч 41,4% нь ажлын эсвэл амралтын өдөр зэргээр хариулсан.

Мэдээлэл солилцох арга нь чухам ямар хэлбэртэй байх талаар илүү дэлгэрэнгүй мэдээллийг ГЯ-аар цуглуулав. Үүнд:

- Төрөл бүрийн хэлбэрийн уулзалт,
- Тараах материал /сонин, товхимол/,
- Гар утас (мессеж, интернэт).

Бусад оролцогчид аль нэг аргыг тухайлаагүй ч дараах шинж байдлыг тусгасан байхыг зөвлөв. Үүнд:

- Зардал багатай,
- Хурдан шуурхай,
- Нарийн тодорхой
- хүртээмжтэй’.

Зарим арга нь бодит байдалтай нийцэхгүй байх талтайг онцолж байв. Тухайлбал, уулзалт, сонин тараах зэрэг нь бэлдэхэд нэлээд хугацаа ордог бөгөөд харьцангуй өртөг өндөр, тийм ч хүртээмжтэй бус гэж үзэв.

ГЯ-д оролцогчид интернэт ашиглах талаар хязгаарлагдмал мэдлэг ойлголттой тул энэ аргыг төдийлөн дэмжээгүй. Тэдний дөнгөж 11% нь компьютер дээр ажиллаж чадна, дор хаяж Facebook ашигладаг чадна. Эдгээр оролцогчид бичил уурхайчидтай ямар шугамаар мэдээлэл солилцдогийг сонирхоход ихэвчлэн утас, уулзалт зэргээр дамжуулдаг аж.

Мэдээлэл солилцох аль нэг аргыг онцолсон оролцогчид үндэслэлээ тайлбарлахдаа, тухайлбал мессеж нь өртөг багатай /160 тэмдэгт нь 25төг/, интернэт ашиглаж чаддаггүй хүмүүсийн хувьд гар утас нь илүү дөхөм байдаг. Зарим тохиолдолд эдгээр аргыг бусад хэлбэрээс арай хүндрэл багатай гэдэг утгаар нь сонгож байв. Жишээ нь, уулзалтын хувьд илүү цаг шаардсан, хүртээмж багатай гэдгийг онцолж байв.

МТ нь тухайлан бичил уурхайчдад зориулагдана гэдэг утгаараа дараах арга хэлбэрийг илүү онцолж байв. Үүнд:

- уулзалт,
- телевиз ашиглах,
- радиогоор дамжуулах (нэг).

Өөр сонголтуудыг бас нэрлэж байв. Үүнд:

⁶Жилд хоёр эсвэл нэг удаа, г.м.

- гар утас (ялангуяа мессеж),
- интернэт (Facebook-ийг илүү онцлох).

Цөөн хэдэн ялгааг эс тооцвол ГЯ-ийн ихэнх оролцогч МТ-ийг дараах давуу талуудтай байж болох юм гэж үзэж байна. Үүнд:

- мэдээлэл цуглуулах боломж,
- төрөл бүрийн сэдэв бүхий мэдээлэл дамжуулах,
- үр дүнтэй (агуулга, өртөг),
- цаг хэмнэх, бага хүчин чармайлт зарцуулах,
- хурдан шуурхай.

Нэг ГЯ-д дурдсанаар “Интернэт тийм ч тохиромжтой арга биш, хөгшин бичил уурхайчид огт хэрэглэдэггүй, зарим залуучууд л хааяа ганц ашигладаг. Гэвч хэрвээ МТ бий болговол интернэт ашигтай байх. Тэд зөвхөн уул уурхай гэлтгүй, бизнесийн талаар мөн мэдээлэл авах боломжтой”. Хэдийгээр энэ нь интернэтийг дэмжээгүй ч МТ-ийн ач холбогдлыг тодотгосон санаа юм. Бусад оролцогчид интернэтэд суурилсан МТ-ийн бас нэг давуу тал нь бичил уурхайчид цаашдаа зайлшгүй компьютер, интернэт ашиглаж сурах хэрэгцээ гарна гэв.

МТ-өөр мэдээлэл дамжуулах давтамжийн талаар бага зэрэг зөрөлдөөнтэй санаанууд гарч ирж байв. Нэлээд олон оролцогч зав зай багатай, давтамжийг тодорхойлох боломжгүй гэв. Гэвч нэг ГЯ-д Facebook-ийг өдөр тутам ашигладаг тул мэдээллийг өдөр бүр шинэчлэх хэрэгтэйг онцолсон.

Ихэнх оролцогч МТ-д мэдээлэл оруулах, шинэчлэх эзэн нь Бичил уурхайчдын нэгдсэн дээвэр холбоо /БУНДХ/ болон ТБУ төсөл гэж үзэж байна. Нэг оролцогчийн хэлснээр хэрвээ Facebook-д суурилбал хүн бүр мэдээлэл оруулах боломжтой болно. МТ-ийг хэрэглэх, мэдээлэл оруулах чадавхийг бэхжүүлэх хүрээнд сургалт явуулж, ухаалаг утас ашиглах зааварчилгаа өгөх нь зүйтэй гэсэн санаа гарч байв.

МТ-ийн мэдээлэл харилцааны стратеги хөгжүүлэх асуудал ФБЯ-ын гол сэдэв байв. Оролцогчид хамгийн түгээмэл бөгөөд тохиромжтой мэдээлэл солилцох арга хэлбэрийг тодорхойлж, дараа нь оноо өгч, эрэмблэн, тус бүрийн давуу ба сул талуудыг нэрлэсэн. Үр дүнг хураангуйлан дараах хүснэгтэд харуулав. Нэг ФБЯ “туршлага судлах аялал”-ыг нэгдүгээрт оруулсан ч өртөг өндөр гэдгийг мөн онцолж байв. Тиймээс хүснэгтэд улаанаар тэмдэглэн, хасах⁷ саналд оруулав.

Бусад арга бол тараах материал, интернэт, ам дамжсан яриа ихэвчлэн гурав дахь сонголтод орж, харьцангуй бага оноо (дунджаар 4.0- 5.5) авсан тул шар өнгөөр тэмдэглэв. Уулзалт, гар утас /мессеж, г.м/, телевиз гэсэн хэлбэрүүд нэг болон хоёрдугаарт эрэмбэлэгдэж, өндөр оноо (дунджаар 6.2 - 7.8) авсан тул хамгийн тохиромжтой арга болох нь харагдаж байна.

⁷Бодит байдалд нийцэхгүй ба өндөр зардалтай.

Хүснэгт 5. ФБЯ-ын оролцогчдын мэдээлэл солилцох тохиромжтой арга хэрэгслийг тодорхойлсон байдал

Аймаг, сум	Мэдээлэл солилцох арга хэрэгсэл						
	Гар утас	Телевиз	Уулзалт	Туршлага судлах аялал	Тараах материал	Ам дамжсан яриа	Интернэт
Баянхонгор, Баян-Овоо	2-р	1-р					3-р
Баянхонгор, Бөмбөгөр	2-р		1-р		3-р		
Дорноговь, Айраг	1-р	3-р			2-р		
Хэнтий, Норовлин	2-р	3-р	1-р				
Сэлэнгэ, Баянгол	2-р		3-р	1-р			
Сэлэнгэ, Мандал	1-р		2-р			3-р	
Төв, Заамар	1-р		2-р			3-р	
Увс, Тариалан	2-р	1-р					3-р
Дундаж оноо (10 хамгийн өндөр)⁸	7.8	7.0	6.2	6.0	5.5	4.5	4.0

Дүгнэлт. Мэдээллийн агуулгын хувьд бичил уурхайн талаар ерөнхий мэдээллээс эхлэн нөхөн сэргээлт зэрэг тодорхой сэдэв хүртэл харилцан адилгүй байна. ТБУ төслөөс зохион байгуулах уулзалтуудад оролцох сонирхолтой ба уулзалт нь сард нэг удаа, ажлын талбарт зохион байгуулагдвал илүү тохиромжтой. ГЯ-аар уулзалтын ач холбогдлыг тодотгосон ч ялангуяа өртөг зардалтай холбоотой үр ашгийг анхаарах нь зүйтэйг онцолсон. Одоогийн зарим хүндрэлийг эс тооцвол интернэтийн хэрэглээг мөн дэмжсэн.

ФБЯ-аар оролцогчид хамгийн тохиромжтой мэдээлэл солилцох арга хэрэгслүүдийг илүү гүнзгийрүүлэн хэлэлцсэн. Тэдний өгсөн саналыг дараах байдлаар дүгнэн харуулж байна.

Хүснэгт6. Мэдээллийн хэрэгслүүдийн арга хэлбэрийг ФБЯ-аар гүнзгийрүүлэн тодорхойлсон байдал

Мэдээллийн хэрэгсэл	Байршил	Хариуцах эзэн	Төвлөрөх газар	Давтамж
 Гар утас	Айраг, Баянгол, Баян-Овоо, Бөмбөгөр, Мандал, Норовлин, Тариалан, Заамар	ТББ, ТБУ төсөл, БУНДХ	--	Долоо хоног тутам
 Уулзалт	Баянгол, Бөмбөгөр, Норовлин, Заамар	ТББ, ТБУ төсөл, БУНДХ	Сумын төв	Сар тутам

⁸ФБЯ-аар гаргаж ирсэн

 Телевиз	Айраг, Баян-Овоо, Тариалан, Норовлин	ТББ, ТБУ төсөл	МҮОНТ Орон нутгийн телевиз TV9 “Малчин”	Сар тутам
 Тараах материал	Айраг, Бөмбөгөр	ТББ	Талбарт	Сар тутам
 Интернэт	Баян-Овоо, Тариалан	ТББ	Facebook Тусгай вэбсайт	Долоо хоногт 2- 3 удаа
 Туршлага судлах аялал	Баянгол	Нөхөрлөлийн ахлагч	Баянхонгор аймгийн Баян- Овоо сум	Жилд хоёр удаа
 Ам дамжсан яриа	Мандал, Заамар	Бичил уурхайчид	--	--

Хамгийн тохиромжтой гурван арга хэрэгсэл нь:

1. Гар утас; ихэнх оролцогч ТББ, ялангуяа ахлагч, ТБУ төсөл болон БУНДХ хариуцах,
2. Уулзалт; дээрхтэй ижил.
3. Телевиз; ТББ, ТБУ төсөл хариуцах ба хамгийн их үздэг суваг нь МҮОНТ, орон нутгийн телевиз, TV9, “Малчин” телевиз.

ФБЯ-аар мөн дараах саналуудыг гаргав. Үүнд:

- Тараах материалыг ТББ бэлтгэн, сард нэг удаа талбар дээр тараах,
- Интернэтэд суурилсан МТ нь Facebook болон бусад вэбсайтыг ашиглах,
- Туршлага судлах аялалыг Баянхонгор аймаг, тэрдундаа Баян-Овоо суманд очиж зохион байгуулах, учир нь тэндхийн бичил уурхайн бүлэг, үйл ажиллагаа нь харьцангуй сайн хөгжсөн гэж үздэг,
- Ам дамжсан яриа мөн нэг сонголт байж болно. Зарим хүн энэ нь найдвар багатай ч маш өртөг багатай, хугацаа хэмнэсэн гэж үзсэн.


Эдгээр үр дүн, дүгнэлт нь одоогийн бодит нөхцөл байдалд тулгуурласан ба ирээдүйн хэрэгцээ шаардлага, боломжийг арай бага тусгасан болно.

4.4. ТБУ төслийн талаар мэдлэг хандлага

Үр дүн (ерөнхий). Дийлэнх респондент (71,7%) ТБУ төслийг хэдийнэ мэддэг аж. Үүнд:


- 28,3% ‘маш сайн мэднэ’
- 43,4% ‘бага зэрэг мэднэ’ эсвэл ‘саяхнаас мэддэг болсон’.

Төслийн талаар анх хаанаас олж мэдсэнийг тодруулбал гол төлөв ТББ, төслийн багаас зохион байгуулсан хурал семинар /тус бүр 40,8 болон 39,1%/ байв.



Дүрслэл8. Асуумжид оролцогчдын ТБУ төслийн талаар сонссон эх сурвалж

ТБУ төслийн талаар мэддэг иргэдийн дунд төслийн талаар эерэг хандлага зонхилж байна. Үүнд 83,9% нь “маш сайн”, “сайн”, “дунд зэрэг” гэсэн хариултууд өгсөн.



Дүрслэл9. ТБУ төслийн талаархи сэтгэгдэл

ТБУ төслийн талаархи сэтгэгдлийг байршлаар нь ялган дараах хүснэгтэд харуулав. Маш цөөн оролцогч төслийг “тааруу”, “маш тааруу” гэж үнэлсэн.

Хүснэгт7. Асуумжид оролцогчдын ТБУ төслийн талаархи сэтгэгдэл, байршлаар.

Аймаг	Сум	Хувь (%)					
		Маш сайн	Сайн	Дунд зэрэг	Муу	Маш муу	Мэдэхгүй
Баянхонгор	Баян-Овоо	13	48	22	0	0	17
	Бөмбөгөр	12	53	23	6	0	6
	Галуут	27	73	0	0	0	0
	Жаргалант	30	65	5	0	0	0
Дархан-Уул	Шарын гол	18	36	0	0	0	46
Дорноговь	Айраг	23	68	5	0	0	5
Дундговь	Хулд	9	33	25	0	0	33
Говь-Алтай	Есөнбулаг	0	70	10	0	0	20
Хэнтий	Норовлин	22	72	0	0	0	6
Сэлэнгэ	Баруунхараа	14	21	29	0	0	36
	Мандал	30	44	17	0	0	9
	Орхонтуул	17	33	33	9	0	8
	Түнхэл	6	12	47	0	0	35
Төв	Заамар	40	25	15	0	0	20
Увс	Тариалан	5	70	5	0	0	20
	Нийт	19	50	15	1	0	15

ТБУ төслийн талаархи сэтгэгдлээ хэрхэн тайлбарласныг дараах дүрслэлд харуулав.



Дүрслэл10.ТБУ төслийн талаархи сэтгэгдлээ тайлбарласан байдал

ФБЯ-д оролцогчид ТБУ төслийн талаар мэддэг хүний тоо бүр ч илүү /90,1%/ бөгөөд тэд төслийг дараах 4 шалгуураар оноо өгч үнэлсэн байна. Үүнд, “хэрэгцээнд нийцсэн эсэх”, “үйл ажиллагаа”, “үр нөлөө”, “орон нутгийн засаг захиргаатай харилцаа уялдаа”. Эдгээр шалгуураар үнэлэхэд 88,4% нь “сайн”, “маш сайн” гэсэн хариу өгсөн.

ФБЯ-ын оролцогчид төслийг дээрх шалгууруудын дагуу хэрхэн үнэлснийг аймаг, сум бүрээр дараах хүснэгтэд харуулав. Тэд 0-5 оноогоор үнэлсэн ба дундаж оноонуудын хооронд тийм ч том ялгаа харагдсангүй.

Хүснэгт8. ФБЯ-ын оролцогчдынТБУ төслийн талаарх үзэл бодол.

Аймаг, сум	Шалгуур				Дундаж
	Хэрэгцээнд нийцсэн эсэх	Үйл ажиллагаа	Үр нөлөө	Орон нутагтай харилцаа уялдаа	
Баянхонгор, Баян-Овоо	4.0	4.0	4.0	4.0	4.0
Баянхонгор, Бөмбөгөр	5.0	5.0	4.5	4.0	4.6
Дорноговь, Айраг	5.0	5.0	5.0	4.0	4.7
Хэнтий, Норовлин	5.0	4.0	4.5	3.0	4.1
Сэлэнгэ, Баянгол	4.0	4.0	5.0	2.5	3.8
Сэлэнгэ, Мандал	4.0	4.0	4.5	4.5	4.2
Төв, Заамар	4.5	4.0	5.0	4.0	4.3
Увс, Тариалан	5.0	5.0	5.0	5.0	5.0
Дундаж оноо	4.5	4.3	4.6	3.8	4.3

ГЯ-д оролцогчдоор тусгайлан төслийн талаар санал сэтгэгдэл аваагүй ч 19 хүний дөрөв нь хурал уулзалт, БУНДХ-ын сайн туршлагыг МТ-д тусгах нь зүйтэй хэмээн дурдсан.

Дүгнэлт.ТБУ төсөл нь асуумж болон ФБЯ-ын оролцогчдын дунд нэлээд сайн танигдсан (тус бүр 71,7% болон 90.1%) ба ерөнхийдөө сайнаар үнэлэгдсэн (тус бүр 83,9 and 88,4%). Төслийн талаар ТББ болон төслийн уулзалтуудаас мэдэж авсан. Бичил уурхайчдын дунд сайнаар танигдсан шалтгаан нь сургалт, дэмжлэг, хамтын ажиллагаа аж. Цөөн хэдэн сөрөг хандлага гарсны шалтгаан нь “тогтвортой бус”, “мэдээлэл хангалтгүй” гэсэн байв. Үүнийг тэд илүү мэдээлэл авах хүсэлтэй байдаг ба өргөн хүрээнд сайнаар танигдсан энэхүү төслийг цаашид илүү урт хугацаанд үргэлжлээсэй гэсэн хүлээлттэй байгааг илтгэж болох юм.

5. ЗӨВЛӨМЖ

5.1. МТ-ийн мэдээлэл солилцох аргачлал⁹

5.1.1. Оршил

Асуумж судалгаанд оролцогчдын нас, бичил уурхайд ажилласан туршлага харилцан адилгүй тул судалгаанд өгсөн санал зөвлөмж нь мөн жигд ялгаатай байлаа. Санаа бодлуудыг хүйс, нас, туршлагаар нь харьцуулахад зарим жижиг ч гэсэн статистик ач холбогдол бүхий хамаарлууд ажиглагдсан. Гэвч төслийн баг МТ-г байгуулж, үйл ажиллагаа явуулахдаа эдгээр холбоо хамаарлыг харгалзаж үзэх нь зүйтэй гэж зөвлөж байна.

Танилцуулга. Судалгааны тайлангийн эхний хувилбарт санал болгосон зөвлөмжийг /ухаалаг утас болон тусгай Facebook хуудас зэрэг вэбэд суурилсан арга хэрэгслийг дэмжсэн/ төслийн баг хүлээн зөвшөөрсний дагуу уг зөвлөмжийг энэхүү Эцсийн тайланд дэлгэрүүлэн боловсруулав. Төслийн МТ бий болгоход дараах мэдээлэл солилцох арга хэлбэрийг санал болгож байна.

Илүү дөхөм болгох үүднээс мэдээлэл солилцох арга хэлбэрийг аль болох тодорхой бүтцэд оруулахыг зорилоо. Зарим нэг бүрэлдэхүүн хэсэг, тухайлбал “төсөв”, “хуваарь” зэрэг нь ТБУ төслийн багийн өгөх мэдээлэлд үндэслэнэ.

Судалгааны үеэр авсан зарим гэрэл зургийг Хавсралт 11-д оруулав.

5.1.2. Одоогийн нөхцөл байдал.

Бичил уурхайчид нас, хүйс, бичил уурхайд ажилласан туршлага, мэдээлэл авдаг суваг, авах хүсэлтэй байгаа мэдээлэл зэргээрээ харилцан адилгүй байв. Гэсэн хэдий ч, ач холбогдол бүхий дараах хоёр санаа гарч ирсэн. Үүнд:

- Уулзалтыг нэлээд их дэмжсэн,
- Ухаалаг утас /мөн интернэт/-ны хүртээмж хэрэглээ хязгаарлагдмал.

Эхнийх нь ТБУ төслийн үйл ажиллагааны цар хүрээ, үр нөлөөтэй холбоотой ба яваандаа ухаалаг утас хэрэглэх боломжтой гэдгийг илтгэж байна. Ухаалаг утас нь бичил уурхайчдын дунд тийм ч их ашиглагддаггүй ба ийм төрлийн утас хэрэглэхийг дэмжиж урамшуулах нь зүйтэй. Мөн мэдээлэл солилцох хамгийн зардал багатай арга гэдгийг аажим ойлгуулах нь зүйтэй юм.

5.1.3. Зорилт; ТБУ Төсөл.

‘Төслийн мэдээлэл солилцох аргачлал нь системтэй байж байж үр дүн нь илүү бодитой болох юм. Хамгийн үр дүнтэй мэдээлэл солилцох арга нь хоёр урсгалтай буюу “өгөх - авах” гэсэн зарчимд тулгуурлах ба хэд хэдэн элементээс тогтсон, тухайн нөхцөл байдалд хариу өгөхөд чиглэгдсэн байх ёстой. ТБУ төслийн төлөвлөлтийн үе шатанд /Хавсралт 5/ хийгдсэн

⁹Нийтлэг философи, ‘аливааг хийх нийтлэг арга зам’ эсвэл ‘эхний санал’ гэж тодорхойлно.

мэдээлэл солилцох санаачилгуудын талаар хийгдсэн судалгаагаар нь мэдээллийн арга хэрэгслүүдийг цогцоор нь хөгжүүлэх нь хамгийн амжилтай гэдэг нь харагдсан. Эдгээр нь вэбсайт, олон нийтийн мэдээллийн группууд, мэргэжилтэн солилцох, туршлага солилцох аялал, сургалт, бичил уурхайн талаарх хурал семинар аж.

Эдгээр арга хэрэгсэл нь сүлжээ холбоог бэхжүүлэх, чадавхийг бэхжүүлэх, үзэл бодлын өөрчлөлт шинэчлэл авчрахад чиглэгдсэн байна. МТ гэдэг нь эдгээр арга хэрэгслийг уялдуулан идэвхитэй ажиллуулах явдал ба төрөл бүрийн аргыг хослуулна гэдэг өөрөө үр дагавар болж байна. Судалгаагаар мөн бичил уурхайчдын дунд мэдээлэл солилцох санаачилгууд /UNDP, UNEP, IADB, Дэлхийн банк, OECD/ хийгдэж бодлогод нөлөөлөх хүчин чармайлт бий болж буйг онцолсон ба эдгээр нь тодорхой нэг асуудлуудаар хязгаарлагдсан байна. Аль ч санаачилга нь бичил уурхайчдын дунд жинхэнэ МТ бий болгох хүртэл хөгжөөгүй.¹⁰

5.1.4. Мэдээлэл солилцох боломжит аргууд.

Хэдийгээр радио хүртээмжтэй, удаан ашиглагддаг ч бичил уурхайчдын дунд тийм ч түгээмэл биш. Телевиз хамгийн түгээмэл ба хоёр сувгийг хамгийн ихээр үздэг аж. Тиймээс, цаашдаа бичил уурхайчдад телевизээр дамжуулан /илүү/ мэдээлэл түгээхийг тэд ихээр дэмжсэн. Гэвч телевизээр нэвтрүүлэг бэлтгэж цацах /ТББ-ын үйл ажиллагаа, хурал семинар, г.м./ нь нэлээд өртөг ихтэй арга юм.

Хүснэгт9. Мэдээлэл солилцох аргуудын шинж чанарыг хураангуйлсан байдал

Зүйл	Шинж чанар	Давуу тал	Сул тал
Радио	Уламжлалт (хуучирсан) технологи, бусад хэрэгслүүдээр солигдож байгаа	Өргөн тархсан	Харьцангуй үнэтэй, хоёр талын харилцаа хязгаарлагдмал
Телевиз	Өндөр технологи (ухаалаг биш бол).	Өргөн тархсан	Өртөг ихтэй, хоёр талын харилцаа хязгаарлагдмал
Уулзалт (туршлага судлах аялал)	Тогтвортой, найдвартай	Түгээмэл, хоёр талын харилцаа сайтай	Өртөг ихтэй (ойролцоогоор 2,7 сая төг), оролцогчдын тоо хязгаарлагдмал тул үр нөлөө бага хүрээг хамарна
Утас (энгийн гар утас)	Өндөр технологи (ухаалаг биш бол).	Өргөн тархсан, өртөг багатай	Limited capacity and limited scope for interaction.
Утас (ухаалаг утас)	Орчин үеийн технологи	Өртөг багатай, багтаамж их, хоёр талын харилцаа хөгжүүлэх боломжтой, өргөн тархах боломжтой	Not (yet) widespread.

Үүний адилаар, ТБУ төслөөс зохион байгуулах уулзалт бас нэлээд дэмжигдсэн. Уулзалтын бэлтгэл болон давтамжаас хамаарч ирээдүйд урт хугацаанд тогтвортой хэрэгжүүлэхэд өртөг өндөр маш өндөр гарна. Гэсэн ч энэ аргыг дунд үе шат хүртэл түр хугацаанд хэрэгжүүлж болох юм.

¹⁰ ТБУ төслийн саналаас ишлэв

5.1.5. Зорилт

Санал болгож буй мэдээлэл солилцох аргачлал нь аажмаар мэдээллийн арга, агуулгын хувьд хувьсан өөрчлөгдөхөд чиглэнэ. Үүнд:

- Оролцогч талуудын мэдээлэлтэй харьцах чадвар, чадавхийг сайжруулах,
- Мэдээллийн чанар, багтаамжийг дээшлүүлэх,
- Өртгийг багасгах,
- Мэдээлэл ашиглалтыг нэмэгдүүлэх.

Санал болгож буй мэдээлэл солилцох аргачлал нь яваандаа уулзалтаас ухаалаг утас ашиглалт руу шилжихэд чадавхийг бэхжүүлэхэд чиглэх нь зүйтэй. Үүний зэрэгцээ мэдээллийн агуулга мөн хөгжиж явах юм.

5.1.6. Мэдээлэл хүлээн авагчид

Мэдээлэл солилцох аргачлалын гол зорилтот бүлэг нь Монголд үйл ажиллагаа явуулж буй бичил уурхайчид юм. Монголын бичил уурхайчдын туршлага олон улсын түвшинд ашиглагдах төлөвтэй байгаа ба донор байгууллагууд өөр улсад хэрэгжиж буй үүнтэй ижил санаачилгыг дэмжиж байна.

5.1.7. Гол мессеж

МТ-д тусгах гол мэдээлэл уул уурхайн талаарх ерөнхий мэдээллээс эхлээд компьютерийн хэрэглээ хүртэл харилцан адилгүй байна. 4-р хэсэгт дурдсан мэдээллийн хэрэгцээнд үндэслэн дараах хүснэгтийг боловсруулав.

Хүснэгт 10. МТ-ийн уулзалтаар хөндөх сэдвүүд

Бичил уурхайн ерөнхий мэдээлэл	Мэргэжлийн уурхай эрхлэх аргууд (тунаах, гүнийн уурхай)	Уул уурхайн инженер
	Бусад орон дахь бичил уурхайн туршлага	Уул уурхайн инженер
	Ашигт малтмал боловсруулах: шинэ технологи	Баяжуулалтын инженер
Албан ёсны зөвшөөрөл авах	Уул уурхайн талаар хэрэгжүүлж буй ЗГ-ын бодлого: уурхайн лиценз авах	Хууль
	Түншлэл, байгууллага байгуулах: Дорноговийн Айраг, Баянхонгорын Жаргалант /Байдраг/-ын жишээ	Бизнес
	Мөнгө санхүүгээ зохистой зарцуулах – хадгаламж, татвар, даатгал	Бизнес
Эрүүл аюулгүй ажиллагаа Байгаль орчин хамгаалах	Уул уурхайн аюулгүй ажиллагааны хэрэгсэл, туршлага	Уул уурхайн инженер
	Уурхайн хог хаягдлын менежмент	Байгаль орчин
	Нөхөн сэргээлт: Баянхонгорын Галуутын туршлага	Байгаль орчин
Технологитой танилцах	Ундны усны эх үүсвэрийг хамгаалах, ашиглах	Байгаль орчин
	Зөөврийн компьютер, ухаалаг утас ашиглах, тэдгээрийн ач холбогдол	Мэдээлэл технологи

Технологитой танилцах сургалт мэдээллийн гол агуулга:

- Ухаалаг утас нь хамгаалах хувцас, өрөмдлөг зэрэг уурхайн үйл ажиллагаанд чухал хэрэгсэл,
- Ухаалаг утас нь өндөр ач холбогдолтой бөгөөд өртөг багатай.

5.1.8. Хэрэгжилт (үе шаттай)

MT-ийг дараах хоёр үе шаттайгаар хэрэгжүүлнэ. Үүнд:

Нэг. Бичил уурхайчдын одоогийн нөхцөл байдалд тохируулах. Тухайлбал, нас, хүйс, туршлага зэрэг хүн ам зүйн үзүүлэлт, мэдээллийн хэрэгцээ, эх үүсвэр /83 нь ухаалаг утасгүй, 27 нь ухаалаг утастай, Facebook ашигладаг/ зэргийг харгалзах.

Хоёр. 2018 онд ТБУ төслийн 4-р үе шат дуусахаас өмнө MT-ийг өөр хэлбэрт шилжүүлэхэд чиглэнэ. Тухайлбал, мэдээллийн хэрэгцээ, хүртээмж /ухаалаг утас, бусад вэбсайт, г.м./ зэрэг нь өөрчлөгдөнө.

Бичил уурхайчдын гуравны хоёр нь ухаалаг утасгүй ба ухаалаг утастай хүмүүс утсаа бүрэн ашиглаж чаддаггүй. MT-ийн онлайн суурьтай бүтцийг илүү үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд компьютер, ухаалаг утас /интернэт орох/ ашиглаж чаддаг хүмүүсийн тоог нэмэгдүүлэх шаардлага тулгарна. Түүнчлэн MT-ийн тогтвортой байдлыг хангахын тулд төслийн уулзалтуудыг яваандаа зогсооход чиглэнэ.

MT-ийн мэдээлэл солилцох аргачлалыг хэрэгжүүлэхэд дараах хоёр үе шатыг дамжина. Үүнд:

1. Одоо явуулж буй уулзалтуудыг /бусад арга/ ашиглан ухаалаг утас /Facebook/-ыг танилцуулж, хэрэглээг хөхүүлэн дэмжиж, компьютер ашиглах сургалт хийх.
2. Үйл явцад мониторинг хийж, жил тутам үр дүнг хэмжих /ухаалаг утасны худалдан авалт, хэрэглээ, компьютер дээр ажиллах чадвар, MT-ийн ач холбогдлын талаар үзэл хандлага зэргээр/

2018 он гэхэд ухаалаг утасны хэрэглээ одоогийн түвшнээс нэлээд өөрчлөгдсөн байна. 2015 онд 27% байгаа бол 2018 онд 83%-д хүргэх.

Уулзалтууд нь дараах давтамжтай хийгдэнэ. Үүнд:


- 1 дэх жил – сар тутам
- 2 дахь жил– улирал тутам
- 3 дахь жил – хагас жил тутам

Төслийн 1 ба 2 дахь жилд онолын мэдлэгийг /бичил уурхайн талаар ерөнхий мэдээлэл, албан ёсны зөвшөөрөл авах, г.м. /зөвхөн онлайн хэлбэрээр өгөх боломжтой. Аюулгүй ажиллагаа, байгаль орчин зэрэг практик мэдлэгийг уулзалтаар өгч болно. Уулзалтын тоог багасгах хуваарийг дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 11. Мэдээдэл өгөх уулзалтыг онлайн МТ-д шилжүүлэх хуваарь

Сэдэв	Сургалтын байршил		
	1 дэх жил (сар тутам)	2 дахь жил (улирал тутам)	3 дахь жил (хагас жил тутам)
Бичил уурхайн ерөнхий мэдээлэл	Уулзалт	Онлайн	Онлайн
Албан ёсны зөвшөөрөл авах	Уулзалт	Онлайн	Онлайн
Эрүүл аюулгүй ажиллагаа	Уулзалт	Уулзалт	Уулзалт
Байгаль орчин хамгаалах	Уулзалт	Уулзалт	Уулзалт
Технологийн мэдлэг	Уулзалт	Шаардлагатай бол үргэлжлэх	Шаардлагатай бол үргэлжлэх

Уулзалт болон онлайн хэлбэрээр олгох мэдээллийн агууламжийн хувийг дараах дүрслэлд багцлав.



Дүрсдэл 11. Уулзалтад суурилсан МТ-ийг интернэт төвтэй болгох шилжилт

Интернэт, ухаалаг утас ашиглах чадавхи харилцан адилгүй тул МТ нь уулзалт, баримт бичиг, интернэт, гар утас гэсэн дөрвөн арыг хослуулсан хэлбэртэй байна. Мэдээлэл солилцох аргачлалыг дараах хүснэгтэд хураангуйлав.

Хүснэгт 12. Санал болгож буй МТ-ийн ерөнхий дүр зураг

Үйл ажиллагаа	Дэлгэрэнгүй
Уулзалт зохион байгуулах	1 дэх жил–сар тутмын уулзалт 2 дахь жил – улирал тутмын уулзалт 3 дахь жил - хагас жилийн уулзалт
Бичиг баримт тараах	Уул уурхайн сэдэвтэй сургалтын гарын авлага Уулзалтаас ирсэн санал хүсэлтийн хураангуй
Facebook-ээр мэдээлэл түгээх	Уулзалтын зар түгээх Уул уурхайн асуудлаархи хэлэлцүүлэг МТ-ийн вэбсайт руу холбогддог линк
МТ-д зориулсан тусгай вэбсайтаар мэдээлэл түгээх	Мэргэжилтнүүдийн боловсруулсан дэлгэрэнгүй мэдээлэлтэй Хэлэлцүүлэг явуулах форумтай
Гар утсаар мессеж түгээх	Уулзалтын зар түгээх Бичил уурхайчидтай шууд холбоо барих боломжтой
Бичил уурхайчдын ТББ-ын мэдээлэл харилцаа хариуцсан хүмүүст сургалт явуулах	ШХА болон бичил уурхайчдын холбоо харилцааны гол хэрэгсэл

МТ-ийн уулзалтууд.

Уулзалт нь мэдээлэл дамжуулах гол арга хэрэгсэл байна. Уулзалт нь дунджаар хагас өдөр үргэлжлэх ба дараах асуудлуудыг хамарсан байна. Үүнд:

- 2 x 90 минутын уул уурхайн сэдэвтэй танилцуулга
- 1 x 15 минутын МТ төслийн талаархи танилцуулга
- 1 x 15 минутын техник технологитой танилцах, багийн дасгал ажил
- 1 x 30 минутын асуулт, хариултын үе шат.

Нэг уулзалтанд ойролцоогоор 25 хүн оролцох ба дараах гол оролцогч талуудыг багтаасан байна. Үүнд:

- 1 x ШХА-ийн томилсон бичил уурхайн мэргэжилтэн
- 1 x ШХА-ийн туслах ажилтан
- 1 x бичил уурхайчдын ТББ-ийн мэдээлэл харилцаа хариуцсан хүн
- Бичил уурхайн нөхөрлөлийн ахлагч нар
- Байгаль орчны мэргэжилтэн /уулзалтын сэдвээс хамаарч/
- Орон нутгийн удирдлагын төлөөлөл /уулзалтын сэдвээс хамаарч/

Техник техонлогитой танилцах хэсэг нь интернэт ашиглан цаг агаарын мэдээтэй хэрхэн танилцах, вэбсайт руу яаж орох, зураг хэрхэн авах зэрэг практик ажлууд орно. Эдгээр нь багийн ажлуудад үндэслэх ба таван хүн дундаа нэг зөөврийн компьютер, ухаалаг утас ашиглана. 25 оролцогчтой уулзалтын хувьд ШХА нийт таван төхөөрөмжөөр хангана гэсэн үг. ШХА-ийн бодлогоос хамаарч эдгээрийн гурав нь ухаалаг утас, хоёр нь зөөврийн компьютер эсвэл таблет байж болох юм.

Цаг хугацаа өнгөрөх тусам мэдлэгийн төвийн уулзалтанд оролцох хүмүүсийн компьютерийн мэдлэгийн түвшин өөр өөр болж болно. Учир нь өмнөх уулзалтанд хамрагдсан оролцогч дараагийн уулзалтанд оролцохгүй харин шинэ (шинэ бичил уурхайч) бичил уурхайч оролцох хүсэлтэй байх магадлалтай. Үүнтэй холбоотойгоор, танилцуулах сургалт болон илүү нарийвчилсан

технологийн сургалтууд хийгдэх шаардлага гарах ба/эсвэл цаг хугацаа өнгөрөх тусам “давтан сургалт хийх, өмнөх сургалтаа залруулах” нь тохиромжтой байж болох юм. Уулзалт зохион байгуулж буй төлөөлөгч эсвэл байгууллага нь учирч болох бүх магадлалуудыг илрүүлж түүнийгээ шийдвэрлэх, тухайн уулзалтыг “сайн” менежменттэй зохион байгуулах явцыг бүрдүүлэх шаардлагатай юм (богино хугацаанд). Харин урт хугацаанд бол технологийн сургалтыг мэдлэгийн төвийн мониторингийн судалгааны нэг хэсэг болгон үр нөлөөг хянаж байх нь зүйтэй. Мониторингийн судалгаа нь мөн уулзалтын явц, агуулга зэргийг үнэлэх, томоохон өөрчлөлтүүдийг тодорхойлох ач холбогдолтой юм.

Уулзалтыг сумын төвд зохион байгуулах нь илүү тохиромжтой гэж үзэж байна. Энэ нь уулзалт зохион байгуулахад шаардлагатай хангамж, тохижилтын асуудлыг шийдэхэд илүү дөхөм. Энэ тохиолдолд талбар дээр голчлон ажилладаг эрчүүдээс илүү гэрийн эзэгтэй нар түлхүү оролцох магадлалтай юм. Гэвч бичил уурхай ихэвчлэн гэр бүлийн бизнес байдаг тул эмэгтэйчүүдэд уулзалтаар мэдээлэл өгч, тэд эрэгтэйчүүдээ цааш мэдлэгээ түгээх боломжтой.

Уулзалтыг ШХА, ТББ-ын мэдээлэл харилцаа хариуцсан гишүүн болон нөхөрлөлийн ахлагч нар хамтран зохион байгуулах боломжтой. Энэ талаар дараах хүснэгтэд дэлгэрүүлэв.

Хүснэгт 13. Уулзалтын зохион байгуулалт

Хугаца	Дэлгэрэнгүй	Хариуцах эзэн
Уулзалтын өмнө	Нөхөрлөлийн ахлагч нартай ярих - уулзалтаас 2 долоо хоногийн өмнө	ТББ-ын мэдээлэл харилцаа хариуцсан гишүүн
	Бичил уурхайчидтай холбогдох	Нөхөрлөлийн ахлагч
	Уулзалтаас 2 өдрийн өмнө нөхөрлөлийн ахлагч руу мессеж бичиж сануулах	ТББ-ын мэдээлэл харилцаа хариуцсан гишүүн
	Сумын төвд уулзалт болох газрыг зохион байгуулах	ТББ-ын мэдээлэл харилцаа хариуцсан гишүүн
Уулзалтын үеэр	Уулзалтын үр дүнг бэлтгэх	ШХА
Уулзалтын дараа	Үр дүнг онлайн хуудсанд тавих	ШХА
	Гарын авлага бэлтгэх	ШХА
	Холбогдох мэдээллийг хаанаас авах талаар бичил уурхайчдад мэдэгдэх	ТББ-ын мэдээлэл харилцаа хариуцсан гишүүн

МТ-ийн уулзалтын хөтөлбөрийн жишээг доорхи хүснэгтэд харуулав.

Зорилго:	Монгол дахь бичил уурхайн өнөөгийн нөхцөл байдал, цаашдын хөгжлийн хандлагын талаар мэдээлэл өгөх
Оролцогчид:	ШХА-ийн мэргэжилтэн #1 - бичил уурхайн мэргэжилтэн ШХА-ийн туслах ажилтан #1 Сумын бичил уурхайчдын ТББ-ын төлөөлөл #1 Бичил уурхайн нөхөрлөлийн ахлагч нар Бичил уурхайчид
Хаана, хэзээ:	4 цаг Сумын төв,
Авчрах зүйлс:	Бал, дэвтэр
Хөтөлбөр:	

Бичил уурхайн талаар ерөнхий мэдээлэл (90 минут)

- Гүний уурхайн арга
- Тунаах арга
- Ашигт малтмал боловсруулах
- Бусад газрын сайн туршлага

Албан ёсны зөвшөөрөл авах тухай (90 минут)

- Уул уурхайн ЗГ-ын бодлого – уурхайн лиценз хэрхэн авах
- Түншлэл, байгууллага хэрхэн байгуулах
- Мөнгө санхүүгийн удирдлага

Бичил уурхайчдын МТ (15 минут)

- МТ байгуулах үндэслэл
- МТ орон нутагт хэрхэн хэрэгжих тухай

Багийн ажил – техник технологи ашиглах (15 минут)

- Ухаалаг утас, зөөврийн утас ашиглах практик дадлага.

Асуулт, хариулт (30 минут)

Дүрслэл 12. МТ-ийн уулзалтын хөтөлбөрийн жишээ

Баримт бичиг

МТ-ийн уулзалтын үр дүнг тусгасан гарын авлагыг уулзалт бүрийн дараа эцэслэн гаргаж, бичил уурхайчдад түгээнэ. Уг нь уулзалт бүрийн дараа гарын авлагыг түгээх нь зөв боловч бодит байдалд нийцүүлэн, дараачийн уулзалтаар тараахаар төлөвлөж болно. Гарын авлагыг ШХА бэлтгэж гаргах юм.

Интернэт

Ухаалаг утасны хэрэглээ одоогоор бичил уурхайчдын дөнгөж дөрөвний нэгийг эзэлж байгаа ч энэ хувийг цаашид тогтвортой нэмэгдүүлэхийг зорино. Ухаалаг утас ашиглах нь өртөг багатай, уян хатан тул Facebook хуудас, МТ-ийн вэбсайт ажиллуулахыг санал болгож байна.

Онлайн МТ-ийн үндсэн мэдээлэл нь МТ-д зориулсан тусгай вэбсайтад тавигдана. Гэсэн хэдий ч нийтлэг хэлэлцүүлэг, олон нийтэд хандсан үйл ажиллагаануудад Facebook хуудас ашиглана. Энэхүү хуудас нь МТ-ийн вэбсайттай тусгай линкээр холбогдсоноор иргэд илүү дэлгэрэнгүй мэдээллийг олж авах боломжтой болно.

МТ-ийн вэбсайтад мэргэжилтэн, орон нутгийн иргэд, орон нутгийн удирдлага дэрэг бичил уурхайд шууд бусаар холбогддог хүмүүс ч мөн орох боломжтой байна. Вэбсайт нь олон нийтийн хэлэлцүүлэг явуулдаг форум хэсэгтэй байна. ШХА-ийн төлөөлөл Facebook болон МТ-ийн вэбсайтыг ажиллуулж өндөр чанартай мэдээлэл тавьж ажиллана.

Эцэст нь, ШХА онлайн МТ-ийг бий болгохдоо зорилтот байршлуудын интернэтийн хурдыг мөн харгалзаж үзэх нь зүйтэй. Судалгаанд хамрагдсан талбаруудын интернэтийн хурд /мэдээлэл оруулах ба татах/-ны талаар мэдээллийг Хавсарлт 12-т орууллаа.

Гар утас

ФБЯ-аар гар утас ашиглах нь мэдээлэл түгээх хамгийн түгээмэл бөгөөд тохиромжтой арга гэж тодорхойлогдсон. Гэвч гар утаснымессеж нь мэдээллийн чанар, багтаамжийн хувьд хязгаарлагдмал юм.

Гар утсыг уулзалтын зар түгээх, сануулга илгээхэд ашиглахад тохиромжтой. ТББ-ын мэдээлэл харилцаа хариуцсан гишүүн нь гишүүддээ мессеж болон дуудлага ашиглан уулзалтын зар мэдээлэх боломжтой. Мөн, уулзалт бүрийн дараа тухайн уулзалтаар өгсөн мэдээллийг хаанаас авч болохыг мэдээлэх боломжтой.

ТББ-ын мэдээлэл харилцаа хариуцсан гишүүдийн сургалт

Уулзалтын үр дүнг нэгтгэж, онлайн МТ-д мэдээлэл оруулахад дэмжлэг болох үүднээс сум бүрт бичил уурхайчдын ТББ-аас нэг нэг мэдээлэл харилцаа хариуцсан гишүүнийг сонгон, сургалтанд хамруулна.

Эдгээр гишүүдэд зориулсан нэг өдрийн сургалтыг Улаанбаатар хотод зохион байгуулна. Сургалтаар компьютерийн мэдлэг, түүнийг бусдадаа хэрхэн түгээх зэрэг ур чадваруудыг эзэмшүүлэхийг зорино.

ШХА үүнд тохиромжтой компьютерийн лаборатори олж, мэдээлэл технологийн болон мэргэжлийн сургагч багш нарыг урьж оролцуулна. Энэхүү сургалтын хөтөлбөрийн жишээг доорхи дүрслэлд харууллаа.

Зорилго:	Оролцогчдын компьютерийн мэдлэгийг дээшлүүлж, энэхүү мэдлэгийг бусдадаа хэрхэн түгээх ур чадвар эзэмшүүлнэ.
Оролцогчид:	ШХА-ийн мэдээлэл технологийн мэргэжилтэн ШХА-ийн мэргэжлийн сургагч багш нар ТББ-уудын мэдээлэл харилцаа хариуцсан гишүүд
Хаана, хэзээ:	Бүтэн өдөр Улаанбаатар хотод
Авчрах зүйлс:	Бал, дэвтэр
Хөтөлбөр:	Хичээл 1: Компьютерийн сургалт (2 цаг) Хичээл 2: Онлайн харилцаа, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл /social media/ ашиглах (1.5 цаг) Хичээл 3: Сургалт явуулах тухай (1 цаг) Дадлага: Бусад гишүүддээ компьютерийн сургалт явуулах дадлага ажил (0.5 цаг) Санал хүсэлт, асуулт хариулт (0.5 цаг)

Дүрслэл13. Мэдээлэл харилцаа хариуцсан гишүүдийн сургалтын хөтөлбөрийн жишээ

5.1.9. Сурталчилгаа.

МТ-ийн талаар тодорхой хэмжээний сурталчилгаа хийснээр үүнийг байгуулах, хэрэгжүүлэх, ажиллуулах явц илүү үр дүнтэй байх болно. Үүнийг ШХА үндэсний түвшинд олон үйл ажиллагаагаараа дамжуулан хэдийнэ эхлүүлсэн ба одоо МТ-д мөн чиглүүлэх нь зүйтэй. Сум бүрт ТББ-ын мэдээлэл харилцаа хариуцсан гишүүдээр дамжуулан сурталчилгааны ажил явуулах боломжтой.

5.1.10. Төсөв.

Санал болгож буй мэдээлэл харилцааны аргачлалыг судалгаанд хамрагдсан 15 суманд нийтэд нь нэвтрүүлэхийн тулд гурван жилийн хугацаанд нийт 270 уулзалтыг бэлтгэн зохион байгуулах шаардлагатай болно.

Зүйл	1 дэх жил	2 дахь жил	3 дахь жил
Уулзалт (тоо)	180	60	30
Зардал (сая, төг)	486	162	81

Нэг уулзалтын зардал дундажаар 2,8 сая төгрөг ба нийт 270 уулзалтын зардал 756 сая төгрөг болж байна. Уулзалтын зардалд сургагч багш/мэдээлэл өгөх мэргэжилтэн /туслах ажилтан/-ий Улаанбаатараас очих аяллын зардал багтсан боловч талбарт ажиллах хугацааны зардлыг оруулаагүй болно.

Хүснэгт 14. Нийтлэг уулзалт хийх дундаж зардлын тооцоолол

Үйл ажиллагаа	Төг/нэгж	Нэгж	Тоо хэмжээ	Нийт (Төг)
Замын зардал	250,000	Нэг тал	4	1,000,000
Томилолт	80,000	Хүн/өдөр	6	480,000
Зууш	18,000	Хүн	30	540,000
Тээврийн зардал	250,000	Хүн	1	250,000
Байр түрээс	100,000	Өдөр	1	100,000
Хэвлэлийн зардал	200,000	Багц	1	200,000
Бичиг хэрэг	8,000	Хүн	30	240,000
Total				2,810,000

Мэдээлэл харилцаа хариуцсан гишүүдийн сургалт /15 сум бүрээс нэг нэг оролцогч/ нь жилд дор хаяж нэг удаа тэднийг Улаанбаатарт авчрахаар төлөвлөгдсөн болно.

5.1.11. Хуваарь.

Санал болгож буй мэдээлэл харилцааны аргачлалыг судалгаанд хамрагдсан бүх 15 суманд хэрэгжүүлэх эсэхээс үл хамааран эхлээд богино хугацааны туршилт уулзалтыг аль нэг талбарт нь хийж, туршилт хэр амжилттай хийгдсэнээс хамаарч бусад талбаруудад нэвтрүүлэх нь зүйтэй.

5.1.12. Мониторинг, үнэлгээ.

Ямар нэгэн интервенц хийх бүрт ахиц дэвшлийг үнэлж, туршилтаас эхлэн үе шаттайгаар хэрэгжүүлэх нь МТ-ийн үнэлгээний хүрээг нэмэгдүүлэх сайн талтай.

5.2. ТБУ Төсөл (4-р үе шат)

ТБУ төсөл нь зорилтот бүлгийн дунд нэлээд сайн танигдсан ба ихэнх нь эерэг хандлагатай байна. Одоо хэрэгжиж буй 4-р үе шат нь хэдэн үе шат бүхий удаан хугацааны интервенцийн сүүлийн шат юм.

Хугацаа	ТБУ төсөл
2005-2007	Чиглэл олгох
2007-2010	II
2011-2014	III

Төслийн сургалт, дэмжлэг, хамтын ажиллагааны үр нөлөө ийнхүү сайшаагдаж буй энэ үед оролцогч талуудын дунд цаашдын ирээдүйн талаар санаа зовних асуудал гарч ирж байж болох юм. Гэвч тодорхойлолт ёсоор төслийн хугацаа хязгаартай тул төслийн 4-р үе шатанд МТ-өөр дамжуулан хийсэн ажлуудынхаа тогтвортой байдлыг хангах томоохон арга хэмжээнүүд авч болохоор байна. Тиймээс ТБУ төсөл /4-р үе шат/ МТ-ийг байгуулахдаа одоо хүртэл хийгдсэн ажлуудыг үргэлжлүүлэх боломжийг бүрдүүлэхэд чиглэх нь зүйтэй хэмээн зөвлөж байна.

ХАВСРАЛТ 1. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Он сар өдөр	Үйл ажиллагаа
3 сарын 27	Гэрээ байгуулах талаар албан бус мэдээ хүлээн авсан
3 сарын 30	ТБУ 4-р шатны төслийн багтай уулзалт хийсэн
3 сарын 31	Захиалагчтай гэрээ байгуулсан
4 сарын 3	Төсөл эхэлсэнтэй холбоотой эхний уулзалт хийгдсэн. Хэрэглэгдэхүүн боловсруулж эхэлсэн.
4 сарын 6	Хэрэглэгдэхүүн боловсруулах шатны төслийн багийн уулзалт.
4 сарын 9	Захиалагчид судалгааны хэрэглэгдэхүүнүүдийг танилцуулсан
4 сарын 9	Захиалагчаас судалгааны хэрэглэгдэхүүн дээр санал ирүүлсэн
4 сарын 10	Захиалагчид сайжруулсан судалгааны хэрэглэгдэхүүнийг танилцуулсан
4 сарын 10	Захиалагчаас туршилт судалгаа хийх зөвшөөрөл авсан.
4 сарын 11	Туршилт судалгаа
4 сарын 13	ИРИМ төслийн багийн туршилт судалгааны үр дүнг хэлэлцэх уулзалт
4 сарын 13	Захиалагчид туршилт судалгааны үр дүнг танилцуулсан
4 сарын 14	Захиалагчаас туршилт судалгааны үр дүн дээр хариу авсан. Талбарын ажлыг эхлүүлэх зөвшөөрөл авсан.
4 сарын 16	Талбарын судлаачдын сургалт хийсэн.
4 сарын 17	Судлаачид талбарт гарсан
4 сарын 18	Мэдээлэл цуглуулалт эхэлсэн.
4 сарын 27	Захиалагчид судалгааны эцсийн тайлангийн хүрээг танилцуулсан
4 сарын 28	Талбарын судлаачидтай товч уулзалт хийсэн
4 сарын 29	Чанарын хяналт, мэдээлэл оруулах ажлууд эхэлсэн.
5 сарын 2	Талбарын мэдээлэл цуглуулалт дууссан.
5 сарын 4	Захиалагчтай уулзалт хийсэн
5 сарын 11	Судалгааны эцсийн тайлангийн урьдчилсан хувилбарыг захиалагчид илгээсэн.
5 сарын 15	Судалгааны эцсийн тайлан дээр захиалагчаас санал авсан
5 сарын 19	Судалгааны гол үр дүнгүүдийг танилцуулах уулзалт хийсэн
5 сарын 22	Сайжруулсан судалгааны эцсийн тайланг захиалагчид явуулсан.

ХАВСРАЛТ 2.НОМ ЗҮЙ

Он сар өдөр	Гарчиг
Ай Ар Ай Эм, 2015	Техникийн санал. 16 хуудас
ШХА, 2014? ¹¹	ТБУ төслийн 4-р шат. 23 хуудас. Төслийн бусад баримт бичиг (ТБУ 4-р үе шатны төслийн баримт бичиг*); 1. Хураангуй (хуу 8, 9), 2. Агуулга (хуу 10-15), 3 Үр дүн болон сургамж (хуу 16-18) болон 4. Зорилтууд (хуу 19-30). Дэд сэдэв '4.1.1. Мэдлэг солилцох Мэдлэг солилцох бүрэлдэхүүний онцлогууд'. Мөн Хавсралт 5-ийг хамарсан. (Одоо байгаа мэдлэгийг хэрхэн солилцох тухай судалгаа.)
ШХА, 2014?	Хоёрдугаар хэсэг: ТБУ мэдлэгийн төвийн тухай ойлголт. 4 хуудас Мэдлэгийн төвийн онцлогийг тайлбарласан баримт бичгээс (ТБУ 4-р үе шатны тухай ойлголт) авав.
ШХА?, 2007	Практик хөгжлийг дэмжих хүний эрх дээр суурилсан хандлага: Хөтөлбөрийн гол асуултууд. 4 хуудас “Эрх баригч” болон “үүрэг хүлээгч”-ийн оролцооны төлөвлөх, дизайн, мониторингийн асуудлын талаарх ШХА-ийн хураангуй.
2014	ТБУ жилийн тайлан*
2012	Монгол Улсын Бичил Уурхайн Орон нутаг дах хүний эрхийн тайлан*
2013	Монгол Улсын Бичил Уурхайн Орон нутаг дах хүний эрхийн тайлан*
Хэвлэлийн Хүрээлэн, 2014	Монголын хэвлэл мэдээлэл өнөөдөр. 107 хуудас. Англи ба Монгол Эзэмшигч, хүний нөөц, нэвтрүүлэг цацах, хэвлэн нийтлүүлэх, уншигчид, үзэгчид болон хэвлэл мэдээллийн салбарын (сонин, сэтгүүл, радио, телевиз болон вэбсайт) төрөл бүрийн мэдээллүүдийг судалсан.

*Ажлын удирдамжийн “бусад” гэсэн хэсэгт дурьдагдсан 6 баримт бичгийн нэг баримт бичиг

¹¹ Асуултын тэмдэг нь мэдээлэл үнэн зөв биш байж болохыг илтгэж байна.

ХАВСРАЛТ 3. ТУРШИЛТ СУДАЛГААНЫ ҮР ДҮН¹²

Туршилт судалгааг Төв аймгийн Сэргэлэн суманд хийхээр төлөвлөж байсан боловч ХАМО нар олдохгүй байх магадлалтай гэсэн шалтгаанаар өөрчлөгдсөн. “Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоо” ТББ нь Гүйцэтгэх захиралын тусламжтайгаар үйл ажиллагаагаа өөрчилсөн. Туршилт судалгаа нь Төв аймгийн Борнуур сумын төв дээр болон Харгант нэртэй олборлолтын талбар дээр 4 сарын 11-ны хагассайн өдөр явагдсан. ИРИМ төслийн багийн 6 гишүүд (Төслийн удирдагч, Зохицуулагч, Ахлах судлаач, Талбарын 3 судлаач) туршилт судалгааны үед дараах ажлуудыг зохих хэмжээнд гүйцэтгэсэн. Үүнд:

- 5 оролцогчидтой нэг ФБЯ,
- 2 ганцаарчилсан ярилцлага (ИТХ-ын дарга болон ахлах бичил уурхайчин),
- 12 асуумж.



Зураг14. Борнуур сумын төвд хийгдсэн ФБЯ.



Зураг15. Харгант олборлолтын талбар дах бичил уурхайчид.

Туршилт судалгааны үед төлөвлөгдөөгүй хүндрэлүүд үүссэн, учир нь тухайн өдөр суманд уулзалтууд (Бичил уурхайчдын сагсны тэмцээн, Намын баяр гэх мэт) давхцсантай холбоотойгоор маш их хэмжээний согтуу хүмүүс байсан.

Ганцаарчилсан ярилцлага болон асуумжийн үр дүнг Хавсралт 1 болон 2-т тус тус танилцуулав.

Туршилт судалгааны үр дүн дээр үндэслэн Ганцаарчилсан ярилцлага (2, 7, 9), асуумж (9, 10, 13, 16, 18) гол гол хийгдвэл зохих засварууд орсон.

¹²4 сарын 13-нд ТБУ төслийн багт танилцуулсан

Хавсралт 1. Туршилт судалгааны ганцаарчилсан ярилцлагын үр дүнгүүд.

1. Та компьютерийн мэдлэгтэй юу? Шивэх, и-мэйл бичих, интернэт ашиглах гэх мэт ¹³
A ¹⁴ . Мэдлэгтэй, дээрх бүгдийг чадна. B ¹⁵ . Дунд зэрэг(и-мэйл шалгах, бага зэрэг интернэт ашиглах).
2. Харилцаа холбооны стратеги боловсруулах талаарх таны ерөнхий санал бодол; (а) ерөнхийд нь (б) ялангуяа бичил уурхайчдын дунд? (та байж болохуйц 3 хүртэлх төрлийн мэдээлэл харилцаа холбооны бүрэлдэхүүн/стратегийг нэрлэнэ үү)
A. Уулзалт хэлэлцүүлэг. B. Тогтмол үнэн зөв мэдээлэл өгөх. A. Бичил уурхайчид интернэт ашигладаггүй, уулзалт хийх хэрэгтэй. B. Бичил уурхайчид хангалтай мэдээлэл авч чаддаггүй.
3. Яагаад?
A. Интернэтийн сүлжээ байдаггүй, тиймээс өөр арга бол байхгүй. Заримдаа телевиз үздэг. B. Уулзалт бол хамгийн үр дүнтэй арга. Радио, гарын авлага тараах зэрэг нь үр дүнгүй.
4. Таньд бичил уурхай эрхлэгчидтэй мэдээлэл солилцож байсан туршлага байгаа юу?
A. Уулзалт, сургалтууд хийгддэг байсан. B. Уулзалт хийдэг, мөн утсаар ярьдаг. Анхаарах. Кейс судалгаанд ашиглах боломжтой материал байвал цуглуулах.
5. Бичил уурхайчдад зориулсан мэдлэгийн төв бий болгоход ямар харилцаа холбооны арга хамгийн тохиромжтой вэ?
A. Нүүр тулсан уулзалт, сайн туршлага солилцох, мөн телевизээр сурталчлах B. Уулзалт.
6. Хэрвээ интернэт дээр суурилсан мэдлэгийн төв бий болвол бичил уурхайчдад ямар үр ашигтай гэж бодож байна вэ?
A. Үр ашигтай, хариуцлагатай байх, хариуцлагын талаар мэдээлэл өгөх хэрэгтэй. B. Мөнгө болон цаг хугацаа хэмнэх боломжтой, Бичил уурхайчдад интернэт ашиглах талаар мэдлэг хэрэгтэй.
7. Бичил уурхайчдын интернэт дээр суурилсан мэдлэгийн төвд та хэр тогтмол мэдээлэл хуваалцах боломжтой вэ?
A. Уул уурхай нь хүлээн зөвшөөрөгдөөгүй салбар, тиймээс бичил уурхайчид бол өөрсдийн ажлынхаа талаар мэдээлэл өгөхгүй. B. Сардаа 1-2 удаа мэдээлэл өгч болно, харин мэдээллийг өдөр бүр авч чадна.
8. Интернэт дээр суурилсан мэдлэгийн төвийн бичил уурхайчдад зориулсан мэдээллийн агуулгыг (ихэвчлэн сайн туршлага) хэн бэлтгэж байх хэрэгтэй гэж бодож байна вэ?
A. Бичил уурхайчдыг ТББ нар төлөөлөх ёстой. Хэрвээ бид тэд нартай гурван талт гэрээ байгуулчихвал орон нутаг мөн мэдээлэл өгөх боломжтой болно. Орон нутаг агуулгыг хөгжүүлэх тал дээр илүү анхаарна. B. Бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоо.
9. Бичил уурхайчдын дунд сайн туршлагын ашиглалт хэрэглээг сайжруулахын тулд ямар нэмэлт чадавхи (эсвэл үр чадвар)-ыг нэмэгдүүлэх шаардлагатай вэ?
A. Сургалтын техникийн тал дээр анхаарах B. Хариулт байхгүй

¹³ Судалгаанд оролцогч нь гол мэдээлэгч мөн эсэх.

¹⁴ Мэдээлэгч А, эрэгтэй, ИТХ-ын дарга.

¹⁵ Мэдээлэгч В, эмэгтэй, орон нутагтаа нэр хүнд бүхий бичил уурхайчин.

Хавсралт 2. Туршилт судалгааны асуумжийн үр дүн.

1. Та хэдэн жил олборлолт хийж байна вэ? (жилээр)	2. Та хэдэн настай вэ? (тоогоор)	3. Таны хүйс? (M/F)
1 -ээс 24; дундаж 7.	25 -аас 57; дундаж 35	Эрэгтэй 75

Анхаарах. Хэрвээ 1-р асуултанд 0 гэсэн хариулт өгсөн бол асуумжийг зогсоох.

4. Байршил? (Аймгийн төв, сумын төв)	5. Таны утасны дугаар хэд вэ? ¹⁶
Төв	Борнуут

6а. Та ухаалаг утас ашигладаг уу? (тийм/үгүй)	6б. Хэрвээ тийм бол ямар загварын утас ашигладаг вэ?		
	1. HTC, LeYüivo, LG, Motorola, Ygüikia, Samsung, and Sony	2. iPhone	3. Бусад
Тийм 42	8 ¹⁷	34	0

7. Та ямар үүрэн телефоны хэрэглэгч вэ?¹⁸

Ж-мобайл	Мобиком	Скайтел	Юнител	Бусад ¹⁹
0	33	8	100	0

Анхаарах. 1 болон түүнээс дээш хариулт байж болно.

8. Та дараах ажилд хэр их цаг зарцуулдаг вэ? (өдөрт)

1. Радио сонсох (цаг)	2. Телевиз үзэх (цаг)	3. Интернэт ашиглах (цаг)
Дундаж (2 оролцогчоос) = 2.0	Дундаж (12 оролцогчоос) = 3.6	Дундаж (4 оролцогчоос) = 1.5

Анхаарах. Цаг зарцуулдаггүй бол 0 гэсэн хариулт бичнэ үү. Хэрвээ телевиз гэсэн хариултан дээр 0 гэж хариулсан тохиолдолд 9-р асуултыг алгасна уу. Хэрвээ интернэт дээр 0 гэж хариулсан тохиолдолд 10 болон 11-р асуултыг алгасна уу.

9. Та аль сувгыг тогтмол үздэг вэ?²⁰

1. MYONT	2. TB5	3. Монгол HD TV	4. Боловсрол ТВ	5. SBN	6. UBS	7. TB9	8. Эх орон ТВ	9. MN25	10. НТВ	11. TB8	12. Ийгл ТВ	13. Орон нутгийн ТВ	14. Байхгүй	15. Бусад Маличн, ETV, Movie box
83	0	0	25	8	25	33	17	8	0	0	8	0	0	42

Анхаарах. 3 хүртэлх хариулт сонгох боломжтой

10. Та ихэвчлэн хаанаас интернэт ордог вэ?(нийт).

1. Утаснаасаа	2. Гэрээсээ	3. Интернэт кафе	4. Ажлаасаа	5. Бусад
100	0	0	0	0

Анхаарах. 1-ээс олон хариулт сонгох боломжтой. Хариултын нийлбэр 100 хувь байх ёстой

¹⁶Чанарын шалгат хийх хэрэгтэй.

¹⁷Ухаалаг гар утас хэрэглэгчдээс.

¹⁸Үр дүнгүүд нь өөр мэдээллийн эх сурвалжтай харьцуулагдах.

¹⁹Бусад гэсэн хариулт бүрийг дэлгэрүүлэх.

²⁰Хариултуудыг сонгохдоо Монголын хэвлэл мэдээлэл өнөөдөр 2014 судалгааны үр дүнгийн хамгийн их үзэгчидтэй телевизүүдээс сонгов.

11. Та ямар вебсайт ашигладаг вэ?

Нэр	Хаяг	Хэрэглэсэн (%)
Орон нутгийн вебсайт		
МУ-ын ашигт малтмалын газар	http://www.mram.gov.mn/index.p	
Уул уурхайн яас	http://www.mm.gov.mn/	
Тусгай хамгаалалттай газар болон экосистемийн орчмын ТБУ	http://www.asm-pace.org/	8.3
ШХА, ТБУ 4-р үе шат	http://www.sam.mn/en.html	
Азийн сан	http://asiafoundation.org/	
The Extractive Industries SourceBook	http://www.eisourcebook.org/	
Фейсбүүк	http://www.facebook.com/	100.0
Твиттер	http://www.twitter.com/	
Инстаграм	http://www.instagram.com/	
YouTube	http://www.youtube.com/	8.3
Байхгүй		
Бусад		

Анхаарах. Давтан асуухгүй байх, 1 болон түүнээс дээш хариулт сонгох боломжтой.

12a. Та хэр тогтмол Фейсбүүк ашигладаг вэ?

Байнга (өдөр бүр)	Тогтмол (цөөн хэдэн өдөрт нэг удаа)	Ховор (долоо хоногт нэг болон түүнээс бага)	Огт үгүй
20	60	20	0

12b. Та Фейсбүүк ямар зорилгоор ашигладаг вэ?

Нийгмийн сүлжээг өргөтгөх	Ажлын зорилгоор	Бусад	Ашигладаггүй
100	0	0	0

13. Та уул уурхайтай холбоотой мэдээллийг ихэвчлэн хаанаас авдаг вэ?

Орон нутгийн удирдалаг (уулзалт)	Уулзалт (Төслийн, ТББ гэх мэт)	Сонин	Төслийн үйл ажиллагаа	Найз нөхөд, хөрш	ТББ үйл ажиллагаа	Телевиз	Радио	Интернэт	Утас	Байхгүй	Бусад
0	25	0	8	67	0	17	0	0	0	0	0

Анхаарах. 3 хүртэлх хариулт сонгох боломжтой

14. Таньд ямар төрлийн уул уурхайтай холбоотой мэдээлэл хамгийн чухал вэ?

Хууль эрх зүй	МУЗГ-ын бодлого	Томоохон уул уурхай	уурхайтай холбоотой ерөнхий	Тусгай зөвшөөрлийн үйлдвэр	Технологи	Алтны худалдаа	Сайн туршлага (уурхайчид)	Бизнес хөгжил (үйлдвэрлэл)	Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа	Байгаль орчин	Нөхөн сэргээлт	Байхгүй	Бусад
25	25	0	17	17	8	8	0	0	33	8	25	8	0

Анхаарах. 3 хүртэлх хариулт сонгох боломжтой.

15. Та ШХА-ийн ТБУ төслийн талаар мэдэх үү?

Тийм, маш сайн	Тийм, бага зэрэг	Үгүй
----------------	------------------	------

мэднэ.	(саяхан мэдсэн)	
42	25	33

Анхаарах. Хэрвээ үгүй гэж хариулсан бол дараагийн асуултыг алгасна уу.

16. Та ШХА-ийн ТБУ төслийн талаарх мэдээллийг хаанаас авсан бэ?

Техникийн дэмжлэг авч байсан	МБУНДХ	Телевиз	Сонин	ТБУ төслийн уулзалт	Бусад
0	25	0	0	38	38 ²¹

Анхаарах. Нэг болон түүнээс дээш хариулт сонгох боломжтой. Сүүлийн дөрвөн хариултыг сонгосон тохиолдолд дэлгэрүүлнэ.

17а. ШХА-ийн ТБУ төслийн талаарх таны сэтгэл ханамж ямар байна вэ?

Маш сайн	Сайн	Дунд зэрэг	Муу	Маш муу	Санал алга
0	13	13	38	0	38

Анхаарах. Зөвхөн нэг хариултыг сонгоно.

17b ТБУ төслийн талаар сэтгэл ханамжийг тайлбарлана уу?

1. Бичил уурхайчдыг зохион байгуулалтанд оруулсан
2. Үр дүнгүй
3. Мэдээлэл дутмаг
4. Эхэн үедээ сайн байсан, одоо бол ямар ч үйл ажиллагаа явагддаггүй
5. Сүүлийн үеийн үйл ажиллагаа нь муудсан
6. Юу ч хийдэггүй
7. Төсөл нь зорилтот бүлэгтээ хүрч чадаагүй

18а. Хэрвээ ТБУ (4-р үе шат) төслөөс мэдлэгийн төв бий болгох уулзалт зохион байгуулахаар бол хаана хийвэл таньд тохиромжтой байна вэ?

Талбар дээр	Сумын төв	Аймгийн төв	Бусад	Оролцохгүй
9	83	0	0	9

Анхаарах. Зөвхөн нэг хариулт сонгоно

18b. Хэрвээ ТБУ (4-р үе шат) төслөөс мэдлэгийн төв бий болгох уулзалт зохион байгуулахаар бол хэзээ зохион байгуулвал таньд тохиромжтой байна вэ?

Долоо хоног тутам	Сар тутам	Улирал тутам	Ажлын өдрүүдэд	Амралтын өдрүүдэд	Бусад	Оролцохгүй
0	42	50	0	0	0	8

Анхаарах. Зөвхөн нэг хариулт сонгоно.

²¹ТББ

ХАВСРАЛТ 4. ФОКУС БҮЛГИЙН ЯРИЛЦЛАГА

Зорилго: Зорилтот бүлгийн “Мэдлэгийн төв” бий болгох судалгааны чанарын мэдээллийг ХАМО нарын оролцоотой цуглуулах.

Зорилт:

1. ХАМО нарын дунд хамгийн түгээмэл бөгөөд үр дүнтэй мэдээлэл харилцааны хэлбэрийг тодорхойлж, цаашид Зорилтот бүлгийн “Мэдлэгийн төв”-ийн хэлбэр, хэв шинжийг хамтын оролцоотой тодорхойлон зураглал үүсгэх
2. ТБУ төслийн талаарх мэдлэг, хандлагыг судлах.

Арга зүй. PRA (Participatory Rural Appraisal) буюу хамтын оролцоотой үнэлгээний арга техник ашиглан, мэдээлэл цуглуулна.

Хэсэг 1.

№	Үе шат	Аргачлал	Чиглүүлэх явц	Хүлээгдэж буй үр дүн	Хугацаа
1.1.	Танилцуулга	Судалгааны зорилго, ФБЯ-ын зааварчилгаа			10 мин
1.2.	Хамгийн түгээмэл хэрэглэгддэг мэдээлэл харилцааны хэрэгслийг тодорхойлох	Санал цуглуулах	“Мэдээлэл харилцаандаа ямар аргыг хамгийн ихээр ашигладаг вэ?” гэсэн асуулт тавьж, хүн бүрт 3 карт тараан, 3 хариулт авна. Нэг картан дээр зөвхөн нэг хариулт бичнэ. Хариултуудыг цуглуулан бүлэглэж, хамгийн их давхардсан хариултуудаар эрэмбэлнэ.	ХАМО нарын дунд хамгийн түгээмэл хэрэглэгддэг 3 мэдээлэл харилцааны хэрэгсэл	10 мин
1.3.	Хамгийн түгээмэл мэдээлэл харилцааны хэрэгслийг үнэлэх	Н-диаграм	Тодорхойлсон 3 мэдээлэл харилцааны хэрэгслийг оноогоор үнэлж, давуу болон сул талуудыг гарган, хэрхэн сайжруулах арга замуудыг жагсаана. 1-р хэрэгслийг бүгд, 2,3-р хэрэгслийг багаар үнэлнэ. (Н-диаграмын зураглалыг хавсралтаас үзнэ үү)	Хамгийн тохиромжтой “Мэдлэгийн төв”-ийг бий болгоход ашиглаж болох санаанууд	30 мин
1.4.	Хамгийн тохиромжтой “Мэдлэгийн төв”-ийн дизайныг гаргах	“Мэдлэгийн төв”-ийн зураглал	Оролцогчдод “Хамгийн тохиромжтой Мэдлэгийн төв ямар байх вэ?” гэсэн асуулт тавьж, зураглал хийлгэнэ. Ингэхдээ дараах үзүүлэлтүүдийг ашиглана: - Мэдлэгийн төв хаана байрлах – эхлэх цэг - Мэдлэгийн төвийг хэн хариуцах - Мэдээллийг ямар давтамжтай оруулах - Мэдээллийг ямар	Мэдлэгийн төвийн менежмент, мэдээллийн давтамж, агуулга, түгээх арга хэлбэр	25 мин

			давтамжтай түгээх - Ямар шугамаар түгээх		
--	--	--	--	--	--

Хэсэг 2.

№	Үе шат	Аргачлал	Чиглүүлэх явц	Хүлээгдэж буй үр дүн	Хугацаа
2.1.	ТБУ төслийн талаарх мэдлэг, хандлагыг тодорхойлох	‘Аалзны тор’ үнэлгээний арга	4-5 индикаторын дагуу 0-5 оноогоор оролцогч бүрээр үнэлүүлнэ. Индикатор буюу сэкцүүд: - Хэрэгцээ шаардлагад нийцсэн эсэх - Орон нутагтай хэр уялдаа холбоотой ажилладаг - Төслийн үйл ажиллагаа - Төслийн үр нөлөө Оноо: 0 - Мэдэхгүй 1- Маш муу 2 - Муу 3 – Дундаж 4 - Сайн 5 - Маш сайн “Аалзны тор”-ын загварыг хавсралтаас үзнэ үү.	ХАМО нарын дундах Төсөл, түүний харилцаа, үр нөлөөний талаарх мэдлэг, хандлага	10 мин

ХАВСРАЛТ 5. ГАНЦААРЧИЛСАН ЯРИЛЦЛАГА

1. Та өөрийгөө компьютерийн мэдлэгтэй гэж бодож байна уу? Шивэх, и-мэйл бичих, интернэт ашиглаж чадна гэх мэт?²²

--

2. Та бичил уурхайчдын харилцаа холбооны стратегид зориулсан бүрэлдэхүүн боловсруулах тал дээр ямар бодолтой байна вэ? (Та байж болохуйц 3 хүртэлх төрлийн мэдээлэл харилцаа холбооны бүрэлдэхүүн/стратегийн жишээ хэлнэ үү)

--

3. Яагаад?

--

4. Та бичил уурхай эрхлэгчидтэй хэрхэн мэдээлэл солилцож байсан бэ?

--

Анхаарах. Холбогдолтой мэдээлэл/ баримт бичиг байгаа бол Кейс Судалгаанд зориулж цуглуулна уу.

5. Бичил уурхайчдад зориулсан мэдлэгийн төв бий болгоход ямар харилцаа холбооны хэлбэр хамгийн тохиромжтой байх вэ?

--

6. Хэрвээ интернэт дээр суурилсан мэдлэгийн төв бий болвол Бичил уурхайчдад ямар үр ашигтай байна гэж та бодож байна вэ?

--

7. Бичил уурхайчдад зориулсан интернэт дээр суурилсан мэдлэгийн төв бий болговол та хэр тогтмол өөрийн мэдээлэл, туршлагаа хуваалцах вэ?

--

8. Бичил уурхай эрхлэгчдэд зориулсан интернэт дээр суурилсан мэдлэгийн төв бий болвол хэн нь гол мэдээллийн агуулгыг (ихэвчлэн сайн туршлага) бэлтгэн оруулж байх ёстой гэж та бодож байна вэ?

--

9. Бичил уул уурхайчдын дунд сайн туршлага нэвтрүүлэхийн тулд бичил уурхайчдын ямар ур чадварыг нэмэгдүүлэх шаардлагатай вэ?

--

²²Судалгаанд оролцогч нь гол түлхүүр ярилцагч мөн эсэхийг батлана.

ХАВСРАЛТ 6. АСУУМЖ

Зөвшөөрлийн хуудас

Асуумжийн код:

Асуумжийн зорилго:

Энэхүү санал асуулгыг “ИРИМ”-судалгааны хүрээлэнгээс явуулж байгаа болно. Судалгааны гол зорилго нь орон нутгийн мэдээллийн харилцаа, холбооны нөхцөл байдал дээр үндэслэн бичил уурхай эрхлэгчдийн дунд хамгийн хүртээмжтэй, урт хугацааны мэдлэгийн төвийг бий болгох тандалт судалгаа хийх юм.

Таны зөвшөөрөлтэйгээр бид судалгааны сэдвийн хүрээнд асуулт асуух бөгөөд асуумж ойролцоогоор 8-15 минут зарцуулагдана.

Мэдээллийн нууцлал болон сайн дурын оролцооны батламж:

Таны хариултын нууцыг судалгааны ажилтнууд Монгол улсын “Статистикийн тухай”, “Хувь хүний нууцын тухай” хуулиудын дагуу бусдад задруулахгүйгээр чандлан хадгална.

Түүнчлэн энэхүү судалгааны үр дүнг судалгааны зорилгоос бусдаар ашиглахгүй бөгөөд, судалгааны үр дүнд таны нэр, нас, хүйс болоод хувийн ямар нэг мэдээлэл дурдагдахгүй болно.

(Би энэ судалгааны талаарх мэдээллийг уншиж танилцлаа. Энэ судалгааны зорилгын талаар асуух зүйлээ би бүрэн асуусан бөгөөд миний асуусан асуултад хангалттай хариулсан. Тиймээс би энэ судалгаанд сайн дураараа оролцож, асуумжид үнэн зөв хариулахаа баталж байна.)

Огноо: он ____ сар ____ өдөр ____

Судлаачийн нэр: _____ Судлаачийн код: [____]

1. Шалгах асуултууд / Бичил уурхайчдын талаарх мэдээлэл /Хамгийн багадаа 2 асуултанд тийм гэж хариулсан бол цааш үргэлжлүүлнэ.

Асуулт	Тийм	Үгүй
Та энэ жил олборлолт хийсэн үү?	1	2
Та бичил уурхайд бүтэн цагаар ажилладаг уу?	1	2
Та бичил уурхайтай холбоотой үйл ажиллагаа, үйлчилгээ үзүүлдэг үү?	1	2
Бичил уул уурхай нь таны/танай өрхийн орлогын эх үүсвэрийн нэг мөн үү?	1	2

2. Та хэдэн жил олборлолт хийж байна вэ? (жилээр)	3. Та хэдэн настай вэ? (тоогоор)	4. Таны хүйс? (эр/эм)

Анхаарах. Хэрвээ 1-р асуултанд 0 гэсэн хариулт өгсөн бол асуумжийг зогсооно.

5. Байршил? (Аймаг/сум)	6. Таны утасны дугаар хэд вэ? ²³

7а. Та ухаалаг утас ашигладаг уу? (тийм/үгүй)	7б. Хэрвээ тийм бол ямар загварын утас ашигладаг вэ?		
	HTC, LeYгүйvo, LG, Motorola, Yгүйkia, Samsung, Sony	iPhone	Бусад

8. Та ямар үүрэн телефоны компаний хэрэглэгч вэ?²⁴

²³Утсан хяналт хийхэд ашиглагдана.

²⁴Үр дүн нь хоёрдогч эх сурвалжийн мэдээлэлтэй харьцуулагдана.

Жи-Мобайл	Мобиком	Скайтел	Юнител	Бусад ²⁵

Анхаарах. 1 болон түүнээс дээш хариулт сонгож болно.

9. Та дараах ажлуудад өдөрт хэдэн цаг зарцуулдаг вэ?

а. Радио сонсох(цаг)	б. Телевиз үзэх(цаг)	в. Интернет ашиглах(цаг)

Анхаарах. Цаг зарцуулдаггүй бол 0 гэсэн хариулт бичнэ үү. Хэрвээ телевиз үзэх дээр 0 гэж хариулсан тохиолдолд 10-р асуултыг алгасна уу. Хэрвээ интернет ашиглах дээр 0 гэж хариулсан тохиолдолд 11 болон 12-р асуултыг алгасна уу.

10. Та аль телевизийн сувгийг тогтмол үздэг вэ?²⁶

а. МҮОНТ	б. ТВ5	в. Монгол HD TV	г. Боловсрол ТВ	д. SBN	е. UBS	ё. ТВ9	ж. Эх Орон ТВ	з. MN25	и. NTV	й. Малчин ТВ	к. ИйглТВ	л. Орон угийн ТВ	м. Байхгүй	н. Бусад

Анхаарах. 3 хүртэлх хариулт сонгох боломжтой; бусад гэсэн хариултыг сонговол дэлгэрүүлж бичнэ.

11. Та ихэвчлэн хаанаас интернет ордог вэ? (хувиар).

Утаснаасаа	Гэрээсээ	Интернэт кафе	Ажил дээрээсээ	Ашигладаггүй

Анхаарах. Нэг болон түүнээс дээш хариулт сонгох боломжтой; Хариултын нийлбэр 100% байх ёстой. Хэрвээ ашигладаггүй гэж хариулсан бол 12, 13а, 13б, 13в асуултуудыг алгасна уу.

12. Та ямар вебсайт ашигладаг вэ?

Нэр	Хаяг	Ашигласан
Орон нутгийн вебсайт (Захиргаа гэх мэт)		
МУ-ын ашигт малтмалын газар	http://www.mram.gov.mn/index.p	
Уул Уурхайн Яам	http://www.mm.gov.mn/	
ТБУ экосистем болон тусгай хамгаалалттай газар	http://www.asm-pace.org/	
ШХА-ын ТБУ төсөл	http://www.sam.mn/en.html	
Азийн сан	http://asiafoundation.org/	
The Extractive Industries SourceBook	http://www.eisourcebook.org/	
Фэйсбүүк	http://www.facebook.com/	
Твиттер	http://www.twitter.com/	
Инстаграм	http://www.instagram.com/	
YouTube	http://www.youtube.com/	
Байхгүй		
Бусад		

Анхаарах. Нэгээс олон хариулт сонгож болно. Давтаж асуухгүй байх.

13а. Та хэр тогтмол Фэйсбүүк ашигладаг вэ?

Байнга (өдөр бүр)	Тогтмол (цөөн хэдэн өдөрт нэг удаа)	Ховор (Долоо хоногт нэг удаа буюу түүнээс бага)	Огт үгүй

²⁵Бусад' гэсэн хариулт болгоныг дэлгэрүүлнэ.

²⁶Хариултанд орсон телевизүүдийг сонгохдоо Хэвлэлийн Хүрээлэнгийн 'Монголын хэвлэл мэдээлэл өнөөдөр 2014' судалгааны дүнгийн Үндэсний хэмжээнд цацагддаг сувгуудаас сонгов

13б. Хэрвээ таны хэрэгцээнд зориулсан бичил уурхайчдын Фэйсбүүк хуудас бий болвол та ашиглах (хувь нэмрээ оруулах уу) уу?

Тийм, мэдээж	Магадгүй	Огт үгүй

13в. Хэрвээ та Бичил уурхайчдад зориулсан Фэйсбүүк хуудсанд нэгдэх хүсэлтэй байгаа бол өөрийн Фэйсбүүк хаягийг өгнө үү.

Оролцогчдийн Фэйсбүүк хаяг

14. Та уул уурхайтай холбоотой мэдээллийг ихэвчлэн хаанаас авдаг вэ?

Орон нутгийн удирдлага (уулзалт, зөвлөгөөн (ТББ, төсөл гэх зэрэг)	Сонин	Төслийн үйл ажиллагаа	Найз нөхөд болон хөрш	ТББ үйл ажиллагаа	Телевиз	Радио	Бичил уурхайчид	Интернэт	Утас	Авдаггүй	Бусад

Анхаарах. 3 хүртэлх хариултыг сонгож болно.

15. Таны хувьд уул уурхайтай холбоотой ямар мэдээлэл хамгийн чухал вэ?

